



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



БОДЛОГЫН ШИЙДЭЛ

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР АЛБАН ХААГЧДААС АВАХ СУДАЛГАА” – НЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2025 он

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР АЛБАН ХААГЧДААС АВАХ СУДАЛГАА” – НЫ ТАЙЛАН

Захиалагч: Авлигатай тэмцэх газар
Гүйцэтгэгч: “Бодлогын шийдэл” ТББ

Улаанбаатар хот, 2025 он

Энэхүү тайлан нь “Шударга байдлын үнэлгээ – 2025” судалгааны “Төрийн байгууллагын шударга байдлын талаар албан хаагчдаас авах судалгаа”-ны тайлан юм.

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг АТГ-аас хараат бус байдлаар гүйцэтгэсэн бөгөөд “Бодлогын шийдэл” ТББ-аас явуулсан судалгаанд оролцогчдын үнэлгээний үр дүнд үндэслэгдсэн болно.

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Доктор Ж.Баттулга

Тайлан боловсруулсан: Доктор Ж.Баттулга

Мэдээлэл цуглуулалтын баг:

Г.Оюун-Эрдэнэ
Ж.Сувдаа
А.Энхтуяа
О.Балжин
З.Сайнжаргал
Л.Баярцэцэг
Б.Гантөмөр
И.Батхишиг
Б.Нарантуяа
Л.Мишээл
Г.Бадамцэцэг
Д.Итгэлмаа
Баяртуяа
Номундарь
Н.Эрдэнэцэцэг

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРАГ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	7
НЭР, ТОМЬЁОНЫ ЖАГСААЛТ	8
ТАЛАРХАЛ	9
ХУРААНГУЙ	1
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	3
1.1. Судалгааны зорилго	3
1.2. Дотоод шударга байдлын үнэлгээний аргачлал	3
1.2.1 Үнэлгээний загвар	3
1.2.2 Үнэлгээний утга	3
1.2.3 Үнэлгээг тооцох арга	4
1.3. Судалгааны хамрах хүрээ	5
1.4. Түүврийн хэмжээ	5
1.5. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	7
БҮЛЭГ 2. ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН	8
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	8
2.2. ДШБҮ-ний ерөнхий дүн	8
2.2.1 Яамдын ДШБҮ-ний дүн	15
2.2.2 Агентлагуудын ДШБҮ-ний дүн	16
2.2.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ДШБҮ-ний дүн	17
2.3. Соёлын индекс	19
2.3.1 Яамдын соёлын индексийн дүн	20
2.3.2 Агентлагуудын соёлын индексийн дүн	21
2.3.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индексийн дүн	23
2.4. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	24
2.4.1 Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн	26
2.4.2 Агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн	27
2.4.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн	28
2.4.4 Чанарын асуултуудын үр дүн	29
2.5 Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ	31
2.6 ДШБҮ-ний гүйцэтгэл бага байгууллагууд	34
2.6.1 Хамгийн бага үнэлгээ бүхий байгууллагууд	34
2.6.2 ДШБҮ хамгийн ихээр буурсан байгууллагууд	38
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ	41
3.1. Монгол Улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, шалтгаан	41
3.2. Авлига хамгийн их тархсан институц	42
3.3. Ирэх 2 жилд Монгол Улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл	44
3.4 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн	44
ДҮГНЭЛТ	46
ХАВСРАЛТУУД	50

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хэмжээст утгад шилжүүлэх загвар.....	4
Хүснэгт 2. Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах	4
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	8
Хүснэгт 4. ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүд, төрийн байгууллагуудын төрлөөр, 2025 он.....	9
Хүснэгт 5. ДШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	14
Хүснэгт 6. Яамдын ДШБҮ-ний эрэмбэ, 2024, 2025 оныг харьцуулсан үнэлгээ	15
Хүснэгт 7. Агентлагуудын ДШБҮ-ний эрэмбэ, 2024, 2025 оныг харьцуулсан үнэлгээ.....	17
Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ-ний эрэмбэ, 2024, 2025 оныг харьцуулсан үнэлгээ	18
Хүснэгт 9. Яамдын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	21
Хүснэгт 10. Агентлагуудын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	22
Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	23
Хүснэгт 12. Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	26
Хүснэгт 13. Агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	27
Хүснэгт 14. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	29
Хүснэгт 15. Байгууллагын шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний саналын нэгтгэл.....	31
Хүснэгт 16. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, 2023-2025 он.....	32
Хүснэгт 17. Дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын индекс, дэд үзүүлэлтээр, 2025	33
Хүснэгт 18. Дүүргүүдийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр.....	33
Хүснэгт 19. Мал эмнэлгийн ерөнхий газрын ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд	34
Хүснэгт 20. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд	35
Хүснэгт 21. Цаг уур орчны шинжилгээний газрын ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд.....	36
Хүснэгт 22. Эрүүл мэндийн яамны ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд.....	37
Хүснэгт 23. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ДШБҮ, дэд үзүүлэлтүүд	38
Хүснэгт 24. ДШБҮ хамгийн их өөрчлөлттэй байгууллагууд	38
Хүснэгт 25. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын ДШБҮ, дэд үзүүлэлтүүд	39
Хүснэгт 26. Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын ДШБҮ, дэд үзүүлэлтүүд	40
Хүснэгт 27. Монгол Улс дахь авлигын үндсэн, шалтгаан нөхцөлийн талаарх төсөөлөл....	42
Хүснэгт 28. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор.....	43
График 1. ДШБҮ, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр, 2025 он	9
График 2. ДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн аймгийн ЗДТГ-ууд	10
График 3. ДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн яамд.....	11
График 4. ДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн агентлагууд	12
График 5. ТБДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн байгууллагууд	12
График 6. ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр	13
График 7. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор	19
График 8. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2025 он	20
График 9. Соёлын индекс хамгийн их өөрчлөгдсөн эхний болон сүүлийн таван агентлаг	23
График 10. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор.....	25

График 11. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр	26
График 12. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан	30
График 13. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд үзүүлэлтээр, дүүрэг тус бүрээр.....	32
График 14. Монгол Улсын авлигын өнөөгийн байдал, хувиар.....	41
График 15. Ирэх 2 жилд Монгол Улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл, хувиар	44
График 16. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар	45
Зураг 1. Үнэлгээний арга зүйн загвар	3

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АТГ	Авлигатай тэмцэх газар
ДШБҮ	Дотоод шударга байдлын үнэлгээ
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МЦБХ	Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтэс
ШБҮ	Шударга байдлын үнэлгээ
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

НЭР, ТОМЬЁОНЫ ЖАГСААЛТ

“Авлига” гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;

“Шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээг;

“Шударга байдлын үнэлгээний судалгаа” гэж гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээг хийхээр зохион байгуулж буй судалгааны нийлбэр цогцыг;

“Дотоод шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй нийтлэг үнэлгээг;

“Төрийн үйлчилгээ” гэж төрийн байгууллага, төрийн албан хаагчаас хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд иргэд, бусад байгууллагад үзүүлж буй аливаа үйлчилгээг тус ойлгох юм.

ТАЛАРХАЛ

“Төрийн байгууллагуудын шударга байдлын талаар төрийн албан хаагчдаас авах судалгаа” – ны ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож судалгааны арга зүйн зөвлөгөө өгсөн “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олонд, мөн судалгааны тоон мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд, судалгааны тоон мэдээлэл цуглуулалтад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье.

ХУРААНГУЙ

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуульд заасны дагуу төрийн байгууллагын шударга байдлын түвшинг 3 багц үзүүлэлтээр тогтмол үнэлж ирсэн. Энэхүү тайланд үнэлгээний 2 дахь багц болох Дотоод шударга байдлын үнэлгээг (ДШБҮ) төрийн захиргааны 81 байгууллагын албан хаагчдын төлөөлөл 2,660 түүврийн нэгжээс асуулгын судалгаагаар тодруулсан үнэлгээний үр дүнг танилцуулж байна. ДШБҮ-г АТГ-ын даргын 2015 оны А/129 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад заасан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын дагуу соёлын индекс, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс гэсэн 2 дэд үзүүлэлтийн дунджаар тооцсон. Уг 2 дэд үзүүлэлтийн дунжийг тооцоход 7 бүлгийн 26 нэгж үзүүлэлтийг ашиглалаа. Өмнөх хоёр оны судалгааны адил төрийн байгууллагуудын дундаж үнэлгээг тооцоходоо дүүргийн ЗДТГ-ын үнэлгээг оруулаагүй буюу нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын үр дүнг тусад нь тооцоолж, танилцуулсан.

2025 онд судалгаанд хамрагдсан 72 төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ 82.41 болж өмнөх онтой харьцуулахад 0.83 оноогоор буурч сүүлийн таван жилийн дараалан өсч байсан хандлагыг зогсоосон үр дүн байлаа. Төрийн байгууллагуудын төрлөөр авч үзвэл яам 0.37, дүүргийн ЗДТГ 1.84 оноогоор тус тус буурсан бол, агентлаг ба аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ харгалзан 0.5 ба 2.2 оноогоор тус тус өссөн байв. Эдгээрээс аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж ДШБҮ хамгийн хамгийн их буюу 83.04 оноогоор үнэлэгдсэн бол бусад төрийн байгууллагууд ойролцоо үнэлгээ авчээ. Төрийн байгууллагын ДШБҮ-ний эрэмбийн хувьд өмнөх оноос их хэмжээний өөрчлөлттэйгөөр жагсаалтын эхний болон сүүлийн 5 байранд орсон байгууллагууд олон байсан ба тайланд түүнд нөлөөлсөн дэд үзүүлэлтүүд, нэгж үзүүлэлтүүдийг нарийвчлан авч үзсэн.

Төрийн байгууллагын төрлүүдийн хувьд яамдын дундаж ДШБҮ 82.26 оноотой, агентлаг ба аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд харгалзан 82.26 ба 83.04 оноогоор тус тус үнэлэгдсэн байна. Энэ онд нийт 72¹ байгууллагаас 39 байгууллагын үнэлгээ өсч, 33 байгууллагын үнэлгээ буурсан. Тэгвэл 2023 ба 2024 онд ДШБҮ үнэлгээ өсөлттэй байсан байгууллагын тоо харгалзан 41 ба 33 байсан нь энэ оны үр дүнгээс их зөрүүтэй байна. Судалгаагаар дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ 82.22 оноогоор үнэлэгдсэн нь төрийн байгууллагуудаас хамгийн их оноогоор буурч үнэлэгдсэн. Тодруулбал, өмнөх оноос 1.84 оноогоор буурч, 9 дүүргээс 7 дүүргийн ДШБҮ буурсан байна.

ДШБҮ-г тооцоход ашигласан хоёр ерөнхий индексээс соёлын индекс нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексээс багаар үнэлэгдсэн хэвээр байлаа. Тухайлбал, соёлын индекс энэ онд 75.56 оноогоор үнэлгээдэж өмнөх оноос 1.7 нэгжээр өсөлт үзүүлсэн бол, удаах индекс 89.26 оноо авч өмнөх жилээс төдийлөн өөрчлөгдөөгүй байв. Уг индексүүдэд хамаарах 7 дэд үзүүлэлтээс авлигын эсрэг тогтолцоо ба удирдлагын хүсэл эрмэлзэл гэсэн үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээг авсан хэвээр байна. Үнэлгээний 26 нэгж асуултуудаас энэ онд үнэлгээ нь хамгийн ихээр буурсан асуултуудыг авч үзвэл “төсвийн зориулалтын бус зарцуулалт (A15)”, энэ асуултын үргэлжлэл болох “төсвийн зориулалтын бус зарцуулалтын хэмжээ (A15-2)”, “удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх (A18)”, “удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх (A17)”, зэрэг асуудлууд байв.

Судалгааны асуулгын хүрээнд үнэлгээний оноонд тооцогдохгүй чанарын асуултуудыг асуусан ба үүнд авлигын тохиолдлын шалтгааныг тодруулсан асуултууд багтсан. Энэ онд мөн Монгол улсын авлигын өнөөгийн нөхцөл байдлыг төрийн

¹ Дүүргийн ЗДТГ-ын үнэлгээг тусад нь тооцож ДШБҮ-г гаргасан тул 72 байгууллагын дундаж үзүүлэлт болно.

байгууллагуудын албан хаагчид хэрхэн үнэлж байгааг тодруулах асуултуудыг асуусан. Судалгааны үр дүн өмнөх онуудтай адил буюу судалгаанд оролцогчдын дийлэнх 60 хувь нь Монгол улсад авлига авах явдал түгээмэл гэж хариулсан ба шалтгааныг тодруулахад цалин хөлсний хэмжээ бага, амьжиргааны түвшний доогуур байдал; хувь хүний хандлага, ухамсар; хуулийн хэрэгжилт сул, хуулиа мөрддөггүй байдал зэрэг хариултууд дийлэнх хувийг бүрдүүлж байна. Цаашлаад Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийг тодорхойлох асуултад Газрын алба, Шүүх, Эрүүл мэндийн байгууллага, Улс төрийн нам болон Гаалийн байгууллагууд хамгийн өндөр хувьтай хэвээр байна. Судалгаанд оролцогчдоос Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг үнэлэх асуултыг асуухад өмнөх жилүүдтэй адил дунд зэрэг болон үр ашиггүй гэсэн хариултын хувь зонхилж байна. Тухайлбал, албан хаагчдын 17 хувь үр ашигтай ба ихээхэн үр ашигтай, 38 хувь нь үр ашиг дунд зэрэг, 22 хувь үр ашиггүй ба огт үр ашиггүй гэсэн хариултыг өгсөн байлаа.

Тухайн байгууллагын үйл ажиллагааны шударга байдлыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлд хийх шаардлагатай үйл ажиллагааг тодруулах асуултад албан хаагчид хамгийн өндөр давтамжтай гурван хариулт нь улс төрийг төрийн албанаас зааглах, төрийн алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, хүмүүсийн ёс суртахууныг сайжруулахад сургалт, сурталчилгаа тогтмол хийдэг байх, үйл ажиллагааг ил тод байлгаж, төрийн үйлчилгээг цахимжуулах, зэрэг зүйлс байсан ба эдгээр хариултууд өмнөх оны үнэлгээнд мөн хамгийн их давтамжтай байсан байна. Үүнээс дүгнэхэд эдгээр хүчин зүйлс нь авлигаас урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа хэвээр байсаар байна.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго

Шударга байдлын үнэлгээний судалгааны багц-2 буюу “Төрийн байгууллагын шударга байдлын талаар албан хаагчдаас авах судалгаа”-ны асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, төрийн байгууллагуудын дотоод шударга байдлын үнэлгээний тайланг боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.


1.2. Дотоод шударга байдлын үнэлгээний аргачлал

Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны А/129 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад заасан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын дагуу дараах загвар, үнэлгээний тооцооллын аргуудыг энэхүү судалгаанд ашиглаж, үнэлгээг тооцсон болно.

1.2.1 Үнэлгээний загвар

Төрийн байгууллагуудын дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ)-г тухайн байгууллагын **соёлын индекс** болон **үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн 7** дэд үзүүлэлт, түүнд хамаарах 26 нэгж үзүүлэлт буюу асуултаар тодорхойлсон. Нэгж асуултуудыг хавсралт 1-ээс харна уу.

Зураг 1. Үнэлгээний арга зүйн загвар



1.2.2 Үнэлгээний утга

Шударга байдлын үнэлгээг дээрх үзүүлэлтүүдээр тооцож, байгууллага тус бүрийн хувьд болон улсын дундаж дүнгээр (төрийн байгууллагуудын дунджаар) гаргана. Шударга байдлын үнэлгээг **0-100** хүртэлх оноогоор гаргасан бөгөөд үнэлгээний утга **100-тай** тэнцүү бол **хамгийн шударгыг** илэрхийлнэ.

1.2.3 Үнэлгээг тооцох арга

ДШБҮ болон түүнийг бүрдүүлэгч үнэлгээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцно.

Дотоод шударга байдлын үнэлгээ $I_i = (A_i + B_i) / 2$

A_i – Соёлын индексийн оноо

B_i – Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын оноо

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулах бөгөөд үзүүлэлтийг хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсхүл байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах гэсэн 2 аргын аль тохирохыг ашиглана.

А. Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох

- 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шилжүүлэх

1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэхдээ дараах загварыг баримтална. Тухайн хариулт эерэг утгатай бол 100 оноог, сөрөг утгатай бол 0 оноог өгөх зарчмыг баримтална.

Хүснэгт 1. Хэмжээст утгад шилжүүлэх загвар

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100 оноо
Түгээмэл	2	25 эсвэл 75 оноо
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25 оноо
Огт байхгүй	5	100 эсвэл 0 оноо

- Үзүүлэлтийн дундаж оноог тооцох

Тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцоход дараах томъёог ашиглана.

$$\text{Үзүүлэлтүүдийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн судалгаанд хамрагдсан нийт хүний тоо}}$$

В. Байгууллагын үнэлгээгээр тооцох

Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах

Байгууллага бүрийн давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулахад тухайн хариултын интервалыг нэг үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай ба дараах байдлаар шилжүүлнэ.

Хүснэгт 2. Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах

Төрөл	Давтамж болон үнийн дүн			
Дотоод шударга байдал	Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, дүр үнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий эд зүйлс өгсөн тохиолдлын	Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, дүр үнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий эд зүйлсийн үнийн дүнг оноожуулах $20000\text{₮}=20$ $21000-50000\text{₮}=35$ $51000-100000\text{₮}=77$	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах байдлын үнийн дүнг оноожуулах $200,000\text{₮}$ $\text{хүртэл}=200$ $201,000-$ $500,000\text{₮}=355$ $501,000-1 \text{ сая}\text{₮}=775$	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/хууль бус үүрэг даалгавар өгөх явдлын давтамжийг оноожуулах $\text{Жилд } 1 \text{ удаа}=1$ $\text{Жилд } 2-3 \text{ удаа}=2.5$ $\text{Улиралд } 1 \text{ удаа}=4$ $\text{Сард } 1 \text{ удаа}=12$

	давтамжийг оноожуулах <i>1удаа=1 2удаа=2 3удаа=3 4-5удаа=4.5 6-10удаа=8 11 ба түүнээс дээш удаа=11</i>	<i>101000-300000₮=205 301000-500000₮=405 501000-1сая₮=755 1.1-2.0сая₮=1550 2.1-5.0сая₮=3550 5.1-10сая₮=7550 10.1сая₮-өөс дээш=10100</i>	<i>1.1-3.0 сая₮=2050 3.1-5.0 сая₮=4050 5.1-10.0 сая₮=7550 10.1-20.0сая₮=15050 20.1-50.0сая₮=35050 50.1-100 сая₮=75050 110.1сая₮-өөс дээш=110100</i>	<i>Сард 2 удаа= 24 Сард 3 болон түүнээс дээш=48</i>
Дунджийг тооцох	Тухайн байгууллагын давтамж, үнийн дүнгийн онооны нийлбэрт үндэслэн тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан нэг хүнд оногдох давтамж, үнийн дүнгийн онооны дунджийг дараах томъёогоор олно. $\text{Нэг хүнд оногдох давтамж, үнийн дүнгийн онооны дундаж} = \frac{\text{Онооны нийлбэр}}{\text{Судалгаанд хамрагдсан нийт хүн}}$			
Оноожуулах	Дунджид үндэслэн бусад байгууллагатай жиших замаар байгууллагын давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах бөгөөд дараах томъёогоор олно. <i>Давтамж үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийн оноо=100*(1-Тухайн байгууллагын давтамж(үнийн дүн)-ийн дундаж/UCP)</i> USP1= бүх байгууллагын давтамж, үнийн дүнгийн дунджаас тооцсон өсөн нэмэгдэх гамма тархалтын 95%-тай тэнцүү утга буюу тухайн жилд хамгийн өндөр давтамж, үнийн дүн бүхий байгууллагын дундаж			

1.3. Судалгааны хамрах хүрээ

Шударга байдлын үнэлгээний судалгаанд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага буюу яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг хамруулдаг. 2025 оны шударга байдлын үнэлгээний судалгаанд нийт **81 байгууллага** (яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ)-ыг хамруулсан ба 2023 оноос ялгаатай нь “Хөрөнгө оруулалт, худалдааны газар” агентлагуудын бүрэлдэхүүнд шинээр орж ирсэн явдал байв.


1.4. Түүврийн хэмжээ

Төрийн байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээний 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, Нийслэл, дүүргийн ЗДТГ- 10 нийт 81 байгууллагын 2660 албан хаагчийг хамруулав. Түүврийн хэмжээ, ангиллыг дараах схемээр харуулав. Түүврийн дэлгэрэнгүй ангиллыг

Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	A1. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A2. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг гэдэгтэй та санал нийлэх үү?
		A3. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг гэдэгтэй та санал нийлэх үү?
		A4. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг гэдэгтэй та санал нийлэх үү?
		A5. Танай байгууллагын алба хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусад дамжуулах явдал хэр байдаг гэж та үзэх вэ?
		A6. Танай байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй холбоотой этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг гэдэгт
Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	Авлигын эсрэг тогтолцоо	A7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй Та санал нийлэх үү?
		A8. Танай байгууллага авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг гэдэгтэй та санал нийлэх үү?
		A9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?
		A10. Танай байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал хэр түгээмэл байдаг вэ?
		A11. Сүүлийн 12 сарын хугацаанд та албан тушаал ахих дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгсөн тохиолдол бий юу?
		A11.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа өгсөн вэ?
		A11.2 Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээний үнэ өртөгтэй байсан бэ?

		A13. Сүүлийн 12 сарын хугацаанд Таны хамтран ажиллагч болон удирдах албан тушаалтан албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэх зорилгоор мөнгө, үнэ бүхий зүйлс өгч байсан уу?
	Төсвийн зарцуулалт	A14. Танай байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал хэр түгээмэл байдаг вэ?
		A15. Сүүлийн 12 сарын хугацаанд Танай байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол бий юу?
		A15.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа тохиолдсон бэ?
		A15.2 Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээтэй үнэ, өртөгтэй байсан бэ?
		A16. Хэрэв тийм бол төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан нь юу вэ?
	Үүрэг даалгаврын шударга байдал	A17. Танай байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?
		A18. Танай байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?
		A19. Сүүлийн 12 сарын хугацаанд Таныг албан үүргээ гүйцэтгэж байхад таны удирдах албан тушаалтан танд хууль бус үүрэг даалгавар өгч байсан уу?
		A19.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр олон удаа тохиолдсон бэ?
		A20. Сүүлийн 12 сарын хугацаанд Танай байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад та болон таны хамтран ажиллагч, удирдагч вэ?
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	A21. Сүүлийн 12 сарын хугацаанд Таны хамтран ажиллагч, удирдах албан тушаалтан албан үүрэгтэйгээ холбоотой бусад талуудаас мөнгө, үнэ бүхий зүйлс авч байсан уу?
		A22. Танай байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг та хэрхэн үнэлэх вэ?
	Удирдлагын хүсэл, эрмэлзэл	A23. Танай байгууллагын дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг Та хэрхэн үнэлэх вэ?
		A24. Өмнөх жилийнхтэй харьцуулахад танай байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн гэж та үзэх вэ?
		A25. Танай байгууллага дахь шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхийг тулд нэн тэргүүнд юу хийх шаардлагатай гэж Та үзэж байна вэ?
		A26. Танай байгууллагад авлигын нөлөө хэр байдаг вэ?

Хавсралт 2-д толилуулав.




1.5. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 05 сарын 20-оос 2025 оны 07 сарын 20-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 28 хүн ажилласан.

Судалгааны багийн гишүүн нь судалгаа хэрхэн авах талаарх аргазүйн сургалтад хамрагдаж, мэдээлэл цуглуулах ажлыг талбар дээр нь ажиллан авсан болно. Мөн бид судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үйл явцыг одоо цаг үед үйлчлүүлж буй иргэд, ААН болон өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН хуваан мэдээллийг цуглуулсан.

Ингэхдээ асуулгын хуудсыг онлайн хэлбэрт шилжүүлэн, тухайн байгууллагын вэбсайт болон ЭБАТ-аас өмнө үйлчлүүлсэн иргэн, ААН-ийн холбогдох утасны дугаар, мэйл хаяг зэрэг мэдээллийг авч холбогдож мэдээлэл цуглууллаа.

Схем 1. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт



БҮЛЭГ 2. ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний мэдээллийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 20 хооронд буюу 2 сарын хугацаанд 2660 төрийн албан хаагчаас мэдээлэл цуглуулан боловсруулалтыг хийж гүйцэтгэв.

ДШБҮ-ээг 16 яам, 34 агентлаг, 31 аймаг, нийслэл, нийслэлийн ЗДТГ-ын 2660 төрийн албан хаагчаас авдаг бөгөөд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 24.8 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 39.8 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 27.1 хувь нь аймаг нийслэлийн ЗДТГ, 8.3 хувь нь дүүргүүдийн ЗДТГ-ын төлөөлөл байв. Судалгаанд оролцсон албан хаагчдын дийлэнх буюу 45 хувийг 5 хүртэлх жил алба хаасан ажилтнууд бүрдүүлж байв.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Үнэлж буй байгууллагын төрлөөр	Яам	660	24.8%
	Агентлаг	1060	39.8%
	Аймаг, нийслэлийн ЗДТГ	710	26.7%
	Дүүргийн ЗДТГ	230	8.6%
Судалгаанд оролцсон төрийн алба хаагчдын ажиллаж буй байгууллагын ангилал	Төрийн захиргааны төв байгууллага буюу яам	632	23.76%
	Төрийн захиргааны байгууллага буюу агентлаг	1076	40.45%
	Төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгж	32	1.20%
	Засаг даргын тамгын газар	805	30.26%
	Засаг даргын харьяа агентлаг	41	1.54%
	Сургууль, цэцэрлэг	2	0.08%
	Эмнэлэг	10	0.38%
	бусад	62	2.33%
Байгууллагад ажилласан жил	5 хүртэл	1187	45%
	5-10	602	23%
	10-20	598	22%
	20-аас дээш	273	10%
Нийт		2660	


2.2. ДШБҮ-ний ерөнхий дүн

Төрийн байгууллагуудын Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) нь тухайн байгууллагын соёлын индекс ба үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс гэсэн хоёр дэд индекс, түүнд хамаарах 7 дэд үзүүлэлт, 26 асуулгын дунджаар тооцогддог. 2025 онд төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ 82.41 болж өмнөх онтой харьцуулахад 0.83 оноогоор өссөн байна. ДШБҮ-г бүрдүүлэгч соёлын индекс ба үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн үнэлгээ энэ онд харгалзан 75.56 ба 89.26 оноогоор үнэлэгдсэн нь соёлын индекс өмнөх оноос 1.72 оноогоор өссөн бол үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 0.07 оноогоор буурч тус тус үнэлэгджээ². ДШБҮ ба дэд индекс бүрийн энэ оны үнэлгээг төрийн байгууллагуудын төрлөөр ба ерөнхий дунджаар тооцоолсныг дараах графикт харуулав. Төрийн байгууллагуудаас Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ ТБШБҮ-ний ерөнхий дунджаас өндөр байгаа бол төрийн захиргааны байгууллага буюу агентлагуудын индекс нь ерөнхий дундаж индексээс үл ялиг багаар үнэлэгджээ.

² 2.3 ба 2.4 дэд бүлгүүдэд энэхүү 2 индексэд хамаарах 7 бүлэг үзүүлэлтийн үнэлгээний үр дүн, түүнд үзүүлсэн нэгж үзүүлэлтийн нөлөөллийг дэлгэрэнгүй тайлбарласан.

Энэ байдлаас дүгнэж үзэхэд төрийн байгууллагуудын хүний нөөц, төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал сайжирсан байгааг харуулж байна. Тодруулбал, төсвийн зарцуулалтыг зориулалтын бусаар зарцуулах явдал буурч, хүний нөөцийн бүрдүүлэлт ил тод, шударга явдаг болсон гэж үзэж болохоор юм. Мөн түүнчлэн удирдлагын дарамт шахалт, хууль бус үүрэг даалгавар өгөх асуудал буурч, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж байгааг эдгээр үр дүн харуулна.

График 1. ДШБҮ, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр, 2025 он



Дээрх хүснэгтээс харахад соёлын индекс нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексээс доогуур үнэлэгдэж байгаа бөгөөд энэхүү хандлага өмнөх онуудад мөн ажиглагдсан байна. Энэхүү хоёр индексийн тооцоололд ашигласан 7 дэд үзүүлэлт бүрийн үнэлгээг төрийн байгууллагуудын ангиллаар дараах хүснэгтэд харуулав. Энд гурван төрлийн байгууллагын хувьд нийтлэг ажиглагдаж буй зүйл нь “авлигын эсрэг тогтолцоо” болон “удирдлагын хүсэл эрмэлзэл” гэсэн хоёр дэд үзүүлэлт доогуур үнэлэгдэж байгаа бол “гадаад орчин дахь авлигатай тэмцэх” болон “хүний нөөц” гэсэн хоёр үзүүлэлт өндөр үнэлгээтэй байна. Энэ зүй тогтол өмнөх жилүүдэд ч мөн ажиглагдаж байсан.

Хүснэгт 4. ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүд, төрийн байгууллагуудын төрлөөр, 2025 он

Төрийн байгууллагын төрөл	Соёлын индекс		Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс				
	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл
Яам	81.05	70.10	94.48	93.25	85.25	99.17	72.63
Агентлаг	80.93	69.09	97.24	91.23	85.30	99.03	72.79
ЗДТГ	83.06	69.73	96.57	93.03	86.73	99.23	72.90

Тайлбар: Онооны дүнг багаас их рүү нь улаанаас, ногоон өнгөөр тэмдэглэсэн байна.


2018 оноос хойш тасралтгүй өсч байсан төрийн байгууллагуудын дотоод шударга байдлын үнэлгээ 2024 онд буурсан бол энэ жилийн судалгаагаар эргэж өссөн нь онцлогтой байна (График 6).

Яамдууд болон нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын ДШБҮ 2024, 2025 онуудад дараалан буурч үнэлэгдсэн бол агентлаг болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 2025 онд өмнөх оноос өсчээ. Мөн түүнчлэн агентлаг, ЗДТГ-уудын хувьд дундаж өсөлт нь 0.5-2.2

оноо байсан бол хамгийн өндөр өсөлттэй Ховд аймаг 17.31 оноогоор нэмэгдсэн ба хамгийн их буурсан Төв аймгийн оноо (7.51↓) байлаа.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн байгууллагууд нь Төв аймаг (↓ 7.51), Баян-Өлгий (↓ 6 оноо)³, Говь-Алтай (↓ 5.37) болон Баянхонгор (↓ 3.96) аймгийн ЗДТГ-ууд олон оноогоор буурсан бөгөөд нийт 9 аймгийн үнэлгээ дунджаар 3.4 оноогоор буурчээ. Харин 13 аймгийн үнэлгээ өссөн бөгөөд өсөлтийн дундаж нь 6.02 оноо байсан нь ерөнхий дундаж үнэлгээнд эерэг нөлөө үзүүлжээ.


График 2. ДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн аймгийн ЗДТГ-ууд



Яамдуудаас 7 яамны үнэлгээ дунджаар 6.22 оноогоор буурсан бол 9 яамны оноо дунджаар 4.18 оноогоор өсчээ. Хэдийгээр оноо нь буурсан яамдаас өссөн яамдын тоо олон боловч үнэлгээ буурсан яамдын оноо өндөр дүнтэй байжээ. Тухайлбал өсөлтөөр тэргүүлсэн Батлан хамгаалах яамны оноо 13.62 оноогоор нэмэгдсэн бол хамгийн ихээр буурсан Эрүүл мэндийн яамны үнэлгээ 17.67 оноогоор буурсан байх жишээтэй байна. Өмнөх онтой харьцуулахад оноо нь хамгийн ихээр буурсан сүүлийн 5 яамыг авч үзвэл Эрүүл мэндийн яам (↓ 17.67), Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (↓ 9.85), Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам (↓ 4.79), Зам тээврийн яам (↓ 4.42), Эрчим хүчний яам (↓ 3.75) -ын үнэлгээ хамгийн ихээр буурсан. Яамдуудын ДШБҮ-ээр хувьд хамгийн бага оноо авсан яамдад дээр дурдсан 5 яамны 4 нь буюу Эрчим хүчний яамнаас бусад нь мөн сүүлийн байруудад жагсаж байна.

³ ↑, ↓ тэмдгүүд ба түүний өмнөх тоон утга нь өмнөх оноос тухайн үзүүлэлт хэдэн оноогоор өссөн ба буурсныг илтгэнэ.

График 3. ДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн яамд




Агентлагуудын хувьд өнгөрсөн оны үнэлгээнээс өсөлтөөрөө тэргүүлсэн газруудад Биеийн тамир, спортын улсын хороо (23.09↑), Цаг уур, орчны шинжилгээний газар (16.89↑) Үндэсний геологийн алба (12.45↑), Оюуны өмчийн газар (10↑), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (7.43↑) – ын үнэлгээ дунджаар 13 оноогоор нэмэгдсэн. Харин шударга байдлын үнэлгээгээр хамгийн их бууралттай агентлагуудад Мал эмнэлгийн ерөнхий газар (↓20.47 оноо), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (↓12.75 оноо), Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар (↓9.87 оноо), Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар (↓8.56 оноо), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (↓7.65 оноо)-ууд өмнөх оноос хамгийн их буурч үнэлэгджээ.

Агентлагуудын үнэлгээнээс харахад өмнөх оноос үнэлгээ нь хамгийн ихээр буурсан 5 агентлагийн 4 нь энэ онд мөн л сүүлийн 6 байрт эрэмбэлэгдсэн байгаа бол үнэлгээ нь өмнө оноос хамгийн ихээр өссөн 5 байгууллагын 2 нь эхний 5 байр үнэлэгдэж байна. Мөн түүнчлэн үнэлгээ нь өнгөрсөн оноос 16.89 оноогоор нэмэгдсэн Цаг уур, орчны шинжилгээний газар 2025 оны эрэмбээр 34 агентлагаас 32 дугаар байрт эрэмбэлэгдсэн байгаа нь онцлог байна.


2025 оны үнэлгээгээр агентлагуудыг Оюуны өмчийн газар 98.13 оноо авч тэргүүлсэн бол Боловсролын ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар удаалжээ. Харин Мал эмнэлгийн ерөнхий газар (59.99), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (67.74), Цаг уур, орчны шинжилгээний газар (70.2) – ууд 70-аас доош оноо авч сүүлийн байруудад эрэмбэлэгдсэн бол агентлагуудын ШБҮ дунджаар 80.06 оноо авч өнгөрсөн жилээр 0.5 оноогоор өссөн.

График 4. ДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн агентлагууд



ДШБҮ-ний дунджид сөргөөр буюу бууруулах нөлөө үзүүлсэн байгууллагуудыг авч үзвэл Мал эмнэлгийн ерөнхий газар (↓ 20.47), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (↓ 12.75), Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газар (↓ 9.87), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (↓ 9.84), Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар (↓ 8.56) - ууд өмнөх оноос хамгийн их буурсан бөгөөд дунджаас доогуур оноо авчээ. Эдгээр байгууллагуудын дийлэнх нь нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, тэр дундаа агентлагууд байгаа нь онцлог харагдаж байна.


График 5. ТБДШБҮ нь өмнөх оноос хамгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн байгууллагууд



Өнгөрсөн онтой харьцуулахад ДШБҮ-ний индекс нь хамгийн ихээр өссөн байгууллагад Биеийн тамир, спортын улсын хороо (23.08↑), Ховд аймгийн ЗДТГ (17.31↑), Цаг уур, орчны шинжилгээний газар (16.89↑), Батлан хамгаалах яам (13.58↑), Үндэсний геологийн алба (12.45↑) зэрэг байгууллагууд эхний 5 дугаар байрт эрэмбэлэгджээ.

Харин ДШБҮ-ээг Оюуны өмчийн газар 98.13 оноо авч 72 байгууллагыг тэргүүлсэн бол Боловсролын ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Сангийн яам, Усны газар, Хөвсгөл аймгийн ЗДТГ зэрэг байгууллагууд 90-ээс дээш оноо авч удаалсан бол нэг (Эрүүл мэндийн) яам, 5 агентлаг 71-ээс доош оноо авч сүүлийн байруудад эрэмбэлэгджээ.

График 6. ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр



ДШБҮ-ний судалгаанд хамрагдсан 72⁴ байгууллагыг эрэмбэлэн харвал 42 байгууллагын ДШБҮ нь ерөнхий дундаж үнэлгээнээс (82.41) дээгүүр байна. 2025 оны судалгаагаар төрийн 72 байгууллагыг Оюуны өмчийн газар 98 оноогоор тэргүүлсэн бөгөөд тус байгууллагын үнэлгээ өмнөх жилээс 10 оноогоор өсчээ.

Оюуны өмчийн газрын үнэлгээний өөрчлөлтөд соёлын индекс 15.61 оноогоор, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 4.39 оноогоор тус тус өссөн нь ДШБҮ-ний өсөлтөд эергээр нөлөө үзүүлээ. Эдгээр индексүүдийг асуултаар задлан харвал, байгууллагын дотоод авлигын эсрэг механизм ба албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавих, бусдын нөлөөлөлд автах байдлыг илэрхийлэх асуултуудын оноо өмнөх жилээс сайжирсан байна. Хамгийн өндөр үнэлгээ авсан эхний 5 байгууллагад Оюуны өмчийн газар, Боловсролын ерөнхий газар зэрэг байгууллагууд өнгөрсөн жил 5 болон 7 дугаар байруудад үнэлэгдэж байжээ. Харин Төрийн цахим үйлчилгээний зохицуулах газрын ДШБҮ өмнөх оноос 7.43 оноогоор нэмэгдэж 32 дугаар байрнаас 3 дугаар байранд, Сангийн яам 4.86 оноогоор нэмэгдэж 23 дугаар байрнаас 4 дүгээр байранд эрэмбэлэгдсэн голлох өөрчлөлт байлаа.

ДШБҮ нь өмнөх оноос ихээр буурсан Мал эмнэлгийн ерөнхий газар 50 дугаар байраас 73 дугаар байрт эрэмбэлэгдэж 23 байр ухарсан бол Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 24 дүгээр байраас 66 дугаар байрт эрэмбэлэгдэж 42 байраар ухарч эрэмбэлэгджээ.

⁴ Дүүргийн ЗДТГ-уудыг тусад нь дүгнэж оруулсан тул 72 байгууллагын үнэлгээг авч үзнэ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын хувьд соёлын индекс, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексүүдэд хамаарах 6 дэд үзүүлэлт бүгд буурсан бөгөөд соёлын индекс 23.28, авлигын эсрэг тогтолцоо 26.72, албан бус хэм хэмжээ 18.83 оноогоор тус тус буурсан бол шударга байдлын үнэлгээ (17.67↓) буурахад төсвийн зарцуулалт (21.93↓), үүрэг даалгаврын шударга байдал (42.97↓), гадаад орчинтой авлигатай тэмцэх байдал (5↓), удирдлагын хүсэл эрмэлзэл (18.76↓) тус тус буурсан нь Мал эмнэлгийн ерөнхий газрын ДШБҮ үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлсэн. Харин үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын дэд үзүүлэлт болох хүний нөөц гэсэн ганц үзүүлэлт өсч (0.3↑) үнэлэгджээ.

Хамгийн ихээр буурсан дэд үзүүлэлтүүдийн асуулгыг авч үзэхэд тус байгууллагын удирдлагаас алба хаагчиддаа хууль бус үүрэг даалгавар өгдөг гэж судалгаанд оролцсон 20 алба хаагчдаас 7 нь хариулсан бөгөөд хууль бус үүрэг даалгаврыг олон удаагийн давтамжтай өгч байсан (сард 3 ба түүнээс дээш удаа гэж 1, улиралд 1 удаа гэж 1, сард нэг удаа гэж 1, сард 2 удаа гэж 1, жилд 2-3 удаа гэж 3 оролцогч тус тус хариулсан) гэж хариулсан байна. Мөн түүнчлэн удирдах албан тушаалтнууд хууль бус үүрэг даалгавар өгөх явдал байдаг (түгээмэл, заримдаа) гэж судалгаанд оролцогчдын 60 хувь нь хариулжээ.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 2025 онд ДШБҮ нь хамгийн ихээр буурсан байгууллагын нэг болсон бөгөөд нөлөөлсөн хүчин зүйлсийг авч үзвэл хоёр индекс, 7 дэд үзүүлэлт бүгд буурч үнэлэгдсэнээс хамгийн ихээр буурсан дэд үзүүлэлтэд авлигын эсрэг тогтолцоо (24.74↓), албан бус хэм хэмжээ (10.5↓), үүрэг даалгаврын биелэлт (11.83↓), удирдлагын хүсэл эрмэлзэл (17.79↓) зэрэг дэд үзүүлэлтүүд хамгийн их оноогоор буюу 10-аас дээш оноогоор буурч үнэлэгджээ.

Хамгийн өндөр болон багаар үнэлэгдсэн тус бүр 5 байгууллагыг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгтээс харахад зарим байгууллагууд хэдийгээр бага оноо авсан боловч өмнөх оноос өсөлт өндөр харагдаж байна. Тухайлбал, Цаг уур, орчны шинжилгээний газар 70.2 оноо авч 70 дугаар байрт эрэмбэлэгдэж байгаа боловч өмнөх жилээс 16.89 оноогоор нэмэгдсэн нь өсөлтөөрөө эхний гурван байрт эрэмбэлэгдэж байна. Нөгөө талаар тус газар сүүлийн хоёр жил дараалан 70-аас хойш байрт эрэмбэлэгдэж байгааг анхаарах хэрэгтэй. Цаг уур, орчны шинжилгээний газрын нь ус цаг уур, орчны шинжилгээ хийх, мэдээ мэдээллээр хангах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зэрэг чиг үүрэгтэй юм. Тухайн байгууллагын үзүүлэлтүүдийн үнэлгээг задалж авч үзвэл, авлигын эсрэг тогтолцоо, албан бус хэм хэмжээнд харгалзаж 48 ба 66 оноо авсан байна. Удирдлагын хүсэл эрмэлзэл дэд үзүүлэлт мөн 60-аас бага оноо авчээ. Харин үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, хүний нөөц зэрэг дэд үзүүлэлтүүдэд 83 ба түүнээс дээш оноо авсан байна.

Хүснэгт 5. ДШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Оюуны өмчийн газар	5	1	88.13	98.13	10.00
2	Боловсролын ерөнхий газар	7	2	87.69	92.09	4.41
3	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	32	3	83.73	91.16	7.43
4	Сангийн яам	23	4	85.66	90.52	4.86
5	Усны газар	14	5	86.52	90.33	3.82
Хамгийн бага үнэлгээтэй:						
68	Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газар	46	68	81.29	71.42	(9.87)

69	Эрүүл мэндийн яам	58	69	77.88	71.33	(6.55)
70	Цаг уур, орчны шинжилгээний газар	72	70	53.31	70.20	16.89
71	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	63	71	75.39	67.74	(7.64)
72	Мал эмнэлгийн ерөнхий газар	50	72	80.46	59.99	(20.47)

Хамгийн бага үнэлгээтэй байгууллагуудын нарийвчилсан шинжилгээг 2.6 дахь хэсэгт харуулав.

2.2.1 Яамдын ДШБҮ-ний дүн

Судалгаанд өмнөх онтой ижил 16 яамны 660 албан хаагчдыг хамруулсан. Яамдын дундаж ДШБҮ 0.37 оноогоор буурч 82.26 оноогоор үнэлэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 9 яамны үнэлгээ дунджаар 4.18 оноогоор өссөн бол 7 яамны үнэлгээ дунджаар 6.22 оноогоор буурсан байна.

2024 оны ШБҮ-ээр яамдын эрэмбээр хамгийн сүүлийн байранд буюу 16 дугаарт жагсаж байсан Батлан хамгаалах яамны 2025 оны үнэлгээгээр 87.52 оноо авч, улмаар хамгийн их буюу 13.58 оноогоор үнэлгээ нь нэмэгдэж 3 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Яамдыг 90.52 оноотой Сангийн яам тэргүүлсэн бол удаах байрт 89.27 оноотой Гадаад хэргийн яам орсон байна.

Харин яамдуудаас хамгийн бага үнэлгээг Эрүүл мэндийн яам 71.33 оноогоор, Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 76.14 оноотой, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 76.15 оноогоор, Зам, тээврийн яам 76.58 оноотой, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 80.61 оноогоор яамдын дунд сүүлийн 5 байрт эрэмбэлэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад яамдуудаас Эрүүл мэндийн яамны үнэлгээ хамгийн ихээр буюу 17.67 оноогоор буурч 16-р байр жагссан нь өмнөх оноос 14 байраар ухарчээ.

Батлан хамгаалах яамны дэд үзүүлэлтүүд бүгд жигд өссөн бөгөөд эдгээрээс албан бус хэм хэмжээ (17.2↑) хамгийн ихээр өссөн бол гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал (6.67↑) хамгийн бага хэмжээгээр нэмэгдсэн байна. Эдгээр дэд үзүүлэлтүүдийн үр дүнд соёлын индекс (14.53↑), үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс (12.64↑) тус тус өсөлттэй байна. Тус байгууллагын албан тушаалтнууд нь авлигын эсрэг тогтолцоог бүрдүүлэх, албан үүргээ биелүүлэх, үүрэг ногдуулах явдалд авлига, ашиг сонирхлын шинжтэй үйлдлийг таслан зогсоох, соёлын хэм хэмжээг бүрдүүлэх чиглэлд тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэж болохоор байна. Батлан хамгаалах яамны хувьд гадаад орчин дахь авлигатай тэмцэх дэд үзүүлэлтээс бусад 6 дэд үзүүлэлтүүд бүгд 10 ба түүнээс дээш оноогоор өссөн (↑) үнэлгээтэй байсан.

Эрүүл мэндийн яамны тухайд 6 дэд үзүүлэлтийн нэгээс бусад нь (хүний нөөц) өмнөх жилтэй харьцуулахад бүгд буурсан ба эдгээрээс төсвийн зарцуулалт (11.67↓), авлигын эсрэг тогтолцоо (9.18↓), удирдлагын хүсэл эрмэлзэл (9.81↓), үүрэг даалгаврын шударга байдал (7.98↓) зэрэг үзүүлэлтүүд хамгийн багаар үнэлэгдсэн байна. Цаашид тус яамны хувьд дээрх үнэлгээг өгсөн шалтгааныг тодруулж, дэд үзүүлэлт бүрээр сайжруулах арга замыг төлөвлөж ажиллах нь чухал байна.

Хүснэгт 6. Яамдын ДШБҮ-ний эрэмбэ, 2024, 2025 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2024	2025	Өөрчлөлт
Яамдын ДШБҮ		82.63	82.26	-0.37
1	Сангийн яам	85.7	90.52	4.82
2	Гадаад харилцааны яам	85.1	89.27	4.17
3	Батлан хамгаалах яам	73.9	87.52	13.62
4	Эдийн засаг, хөгжлийн яам	77.9	86.96	9.06
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	83.4	85.23	1.83
6	Боловсролын яам	81.4	84.02	2.62
7	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	83	83.78	0.78
8	Эрчим хүчний яам	86.9	83.15	(3.75)

№	Байгууллагын нэр	2024	2025	Өөрчлөлт
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	81.7	82.19	0.49
10	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	83.4	81.94	(1.46)
11	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	82.4	80.84	(1.56)
12	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	85.4	80.61	(4.79)
13	Зам, тээврийн яам	81	76.58	(4.42)
14	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	86	76.15	(9.85)
15	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	75.9	76.14	0.24
16	Эрүүл мэндийн яам	89	71.33	(17.67)

2.2.2 Агентлагуудын ДШБҮ-ний дүн

2025 оны шударга байдлын үнэлгээний судалгаанд нийт 34 агентлаг хамрагдаж, агентлагуудын ДШБҮ 82.07 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 0.5 оноогоор нэмэгдсэн байна. ДШБҮ-ээр 16 агентлаг үнэлгээгээ өмнөх оноос сайжруулсан ба 18 агентлагийн үнэлгээ өмнөх оноос буурсан. Харин 2025 оны ДШБҮ-ний дундаж үзүүлэлтээс 22 агентлагийн үнэлгээ дунджаас дээгүүр үнэлэгдсэн бол 12 байгууллагын ДШБҮ дундаас (82.06) доогуур түвшинд байна. Агентлагуудыг эрэмбэлэхэд Оюуны өмчийн газар хамгийн өндөр үнэлгээтэй буюу өмнөх жилийн байраа ахиулсан. Харин Биеийн тамир, спортын улсын хороо, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг агентлагуудын үнэлгээ энэ онд мэдэгдэхүйц сайжирч өмнөх жил 33 ба 23 дугаар байрнаас 9 ба 5-рт эрэмбэлэгдсэн байна. Биеийн тамир, спортын улсын хорооны хувьд хүний нөөц (44.38↑)-д өгсөн үнэлгээ, харин Онцгой байдлын ерөнхий газарт төсвийн зарцуулалтын үнэлгээнүүд (11.52↑) бусад дэд үзүүлэлтээс харьцангуй өндөр өссөн байна.

Харин Мал эмнэлгийн ерөнхий газрын үнэлгээ өмнөх оноос үнэмлэхүй буурсан (20.47) шалтгааныг дэд үзүүлэлтүүдийн бууралтаар өмнө тайлбарласан билээ. Энэ удаа тухайн байгууллагын 20 албан тушаалтнаас байгууллагын шударга ёсыг бэхжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай ажлын талаарх нээлттэй асуултын хариултыг дүгнэж үзэхэд “Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг таслан зогсоох, хувь хүний хариуцлага, ёс зүйг сайжруулах, төрийн байгууллагууд эрхэлж буй үйл ажиллагаагаа нээлттэй ил тод болгох, мэдээллийг тэнцвэртэй, хүртээмжтэй түгээх, хяналт болон хариуцлагын тогтолцоог сайжруулах, улс төр, бизнесээс ангид ажиллах, хууль сахиулах, хариуцлагатай байх” зэрэг хариултуудыг өгсөн байна. Өөрөөр хэлбэл, багаар үнэлсэн дэд үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг судалгаанд оролцогчид ийнхүү дурдсан байна.

Үнэлгээ нь өмнөх оноос ихээр буурч, сүүлээр эрэмбэлэгдсэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үнэлгээг задлан шинжлэхэд дараах зүйлс ажиглагдаж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үнэлгээний дэд үзүүлэлтүүд бүгд буурч үнэлэгдсэнээс авлигын эсрэг тогтолцоо (13.58 ↓), үүрэг даалгаврын шударга байдал (13.29 ↓) болон төсвийн зарцуулалтын (19.92 ↓) үзүүлэлтүүд хамгийн их буурсан байна. Тус байгууллагын асуулгыг задалж үзэхэд төсвийн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулдаггүй хэмээн хариулсан бөгөөд тухайн асуулгын үнэлгээ нь 100 оноо байхаас 86 оноо авсан бол залгамж холбоо асуултууд болох давтамж, төсвийн зориулалтын бус зарцуулалтын хэмжээг тодорхойлох асуултуудад 32 ба 54 оноо авсан нь харьцангуй муу үзүүлэлт байж, улмаар ДШБҮ-д сөргөөр нөлөөлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хувьд мөн дээрх асуудал болох төсвийн зарцуулалтыг зориулалтын бусаар зарцуулдаг (55.66↓) гэж судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 20 хувь нь хариулсан бөгөөд тус байгууллагын ДШБҮ-нд бага оноо авахад нөлөөлсөн байна. Тус газрын төсвийн зориулалтын бус зарцуулалтын

үнэлгээний бууралт нь судалгаанд хамрагдсан нийт байгууллагуудын бүх асуудлуудын хамгийн бага үнэлгээ бөгөөд хамгийн их бууралттай үзүүлэлт болжээ.

Хүснэгт 7. Агентлагуудын ДШБҮ-ний эрэмбэ, 2024, 2025 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2024	2025	Өөрчлөлт
<i>Агентлагуудын ДШБҮ</i>		81.59	81.72	0.13
1	Биеийн тамир, спортын улсын хороо	62.96	86.05	23.09
2	Цаг уур, орчны шинжилгээний газар	53.31	70.2	16.89
3	Үндэсний геологийн алба	73.49	85.94	12.45
4	Оюуны өмчийн газар	88.13	98.13	10
5	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	83.73	91.16	7.43
6	Төрийн худалдан авах ажиллагааны газар	76.8	83.99	7.19
7	Ашигт малтмал, газрын тосны газар	72.2	78.86	6.66
8	Онцгой байдлын ерөнхий газар	81.72	87.74	6.02
9	Архивын ерөнхий газар	75.45	80.04	4.59
10	Боловсролын ерөнхий газар	87.69	92.09	4.4
11	Усны газар	86.52	90.33	3.81
12	Шүүх шинжилгээний ерөнхий газар	82.83	85.36	2.53
13	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	84.75	86.84	2.09
14	Монополын эсрэг газар	83.23	85.28	2.05
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	85.48	87.01	1.53
16	Стандарт, хэмжил зүйн газар	83.99	84.91	0.92
17	Татварын ерөнхий газар	85.75	85.72	-0.03
18	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	86.86	86.48	-0.38
19	Улсын бүртгэлийн ерөнхий газар	85.8	85.3	-0.5
20	Иргэний нисэхийн ерөнхий газар	80.71	79.06	-1.65
21	Нийгмийн даатгалын ерөнхий газар	85.83	83.43	-2.4
22	Гадаадын иргэн харьяатын газар	86.94	84.49	-2.45
23	Цагдаагийн ерөнхий газар	88.13	85.46	-2.67
24	Ойн газар	75.56	72.67	-2.89
25	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	85.9	82.83	-3.07
26	Соёл урлагийн газар	82.76	78.69	-4.07
27	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	84.55	79.55	-5
28	Гаалийн ерөнхий газар	82.43	77.32	-5.11
29	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	85.95	80.14	-5.81
30	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	75.39	67.74	-7.65
31	Жижиг, дунд үйлдвэрийн газар	91.73	83.17	-8.56
32	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	81.29	71.42	-9.87
33	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	85.58	72.83	-12.75
34	Мал эмнэлгийн ерөнхий газар	80.46	59.99	-20.47

2.2.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ДШБҮ-ний дүн

21 аймаг болон нийслэлийн ЗДТГ-уудын дундаж ДШБҮ нь 83.04 болж өмнөх оноос 2.2 оноогоор нэмэгджээ. ЗДТГ-уудаас 13 нь өмнөх жилийн үнэлгээг сайжруулсан ба нийт 9 аймгийн ЗДТГ-ын үнэлгээ өмнөх оноос буурч үнэлэгдсэн. Харин аймаг, нийслэлийн ЗДТГ-ын 2025 оны ДШБҮ-ий дунджаас 11 аймаг дээгүүр түвшинд байсан бол яг тал нь дунджаас доогуур үнэлэгдсэн байна. Аймгуудын үнэлгээ ийнхүү өмнөх оноос 2.2 оноогоор нэмэгдсэн нь төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ-д нэмэгдэхэд голлох нөлөөг үзүүлсэн байна.

Энэ оны судалгааны үр дүнгээр өмнөх жилд 8, 15-р эрэмбүүдэд байсан Хөвсгөл, Увс аймгуудын ЗДТГ-ууд авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа сайжруулснаар ДШБҮ нь өндөр өсөлт үзүүлж, эхний байрууд руу дэвшин харгалзан 1 ба 2 дугаар байрт жагссан байна. Дээрх хоёр аймгийн ЗДТГ-ыг үнэлсэн дэд үнэлгээнүүдийн үр дүн харилцан адилгүй байна. Тухайлбал, Увс аймгийн хувьд авлигын эсрэг тогтолцоо ба удирдлагын хүсэл эрмэлзэл

гэсэн дэд үзүүлэлтүүдийн үнэлгээнүүд хамгийн ихээр өссөн байхад төсвийн зарцуулалт буурч, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдалд өөрчлөлт ороогүй байна. Харин Хөвсгөл аймгийн хувьд хоёр дэд үзүүлэлт буурсан бөгөөд үүнд хүний нөөц 2 оноогоор, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал 3.3 оноогоор тус тус буурсан бол бусад үзүүлэлтүүд өссөн байна. Өссөн үзүүлэлтүүдээс соёлын индекс хамаарах хоёр дэд үзүүлэлт 10-аас дээш оноогоор өссөн дүн гарчээ. Тус аймгийн соёлын индекс 13.44 оноогоор өссөн бол үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс ердөө 0.04 оноогоор нэмэгдсэн байна.

Өмнөх жилд 1-7 дугаар байруудын хооронд эрэмбэлэгдэж байсан Баянхонгор, Говь-Алтай, Төв, Булган аймгуудын ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурч энэ оны сүүлийн байруудад байна. Эдгээрээс Төв аймгийн ЗДТГ-ын ДШБҮ нь өмнөх оноос үнэмлэхүй буурсан шалтгааныг дэд үзүүлэлт бүрээр нь дүгнэж үзэхэд зургаан дэд үзүүлэлт буурсан бол, нэг дэд үзүүлэлтэд өөрчлөлт ороогүй байна. Эдгээрийг задалж авч үзвэл, Хүний нөөц (28.81↓), Удирдлагын хүсэл эрмэлзэл (12.10↓) зэрэг үзүүлэлтүүд үнэмлэхүй хэмжээгээр буурчээ. Тус аймгийн хамгийн бууралттай асуулгыг тодорхойлбол А11.2 дугаар асуултад 100 оноо авахаас 0 авсан нь үнэлгээний үзүүлэлтэд ихээхэн нөлөөтэй байлаа. Тус асуулгаар **Төв аймгийн ЗДТГ-т ажиллаж буй төрийн албан хаагч албан тушаал ахих, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө үнэ бүхий зүйлс буюу 1.1-2 сая төгрөг 1-2 удаа өгч байсан гэж судалгаанд оролцсон 30 албан хаагчаас зарим албан хаагчид хариулсан байна.**

Төв аймгийн ЗДТГ-ын судалгаанд оролцсон төрийн алба хаагчдын нээлттэй асуултын хариултаас харахад тухайн байгууллагад дотоод хяналт шалгалт муу, авлига ашиг сонирхлын талаарх хууль, эрх зүйн мэдээлэл, мэдлэг дутмаг, иргэдэд өгөх мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хувь хүний ёс зүйгүй үйлдэл, шударга бус байдал их байдаг бөгөөд сургалт зохион байгуулах шаардлагатай гэж хариулсан байна.

Харин Говь-Алтай аймгийн хувьд гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдлаас бусад дэд үзүүлэлт бууралттай, үүнээс төсвийн зарцуулалт (21.63↓) хамгийн их оноогоор буурсан байна.

Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ-ний эрэмбэ, 2024, 2025 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2024	2025	Өөрчлөлт
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ	80.88	83.04	2.16
1	Хөвсгөл аймгийн ЗДТГ	83.49	90.23	6.74
2	Увс аймгийн ЗДТГ	79.22	88.48	9.26
3	Дорноговь аймгийн ЗДТГ	87.08	87.98	0.90
4	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	88.77	87.69	(1.08)
5	Архангай аймгийн ЗДТГ	84.48	87.60	3.12
6	Дархан-Уул аймгийн ЗДТГ	80.82	87.51	6.69
7	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	82.15	85.69	3.54
8	Баянхонгор аймгийн ЗДТГ	89.14	85.18	(3.96)
9	Орхон аймгийн ЗДТГ	85.95	85.08	(0.87)
10	Булган аймгийн ЗДТГ	87.4	84.31	(3.09)
11	Өвөрхангай аймгийн ЗДТГ	79.31	83.43	4.12
12	Өмнөговь аймгийн ЗДТГ	79.23	82.59	3.36
13	Дорнод аймгийн ЗДТГ	79.23	82.53	3.30
14	Дундговь аймгийн ЗДТГ	74.49	81.94	7.45
15	Говь-Алтай аймгийн ЗДТГ	85.77	80.40	(5.37)
16	Сүхбаатар аймгийн ЗДТГ	70.59	79.83	9.24


17	Төв аймгийн ЗДТГ	87.23	79.72	(7.51)
18	Ховд аймгийн ЗДТГ	61.99	79.30	17.31
19	Нийслэлийн ЗДТГ	80.12	78.96	(1.16)
20	Завхан аймгийн ЗДТГ	74.88	78.09	3.21
21	Хэнтий аймгийн ЗДТГ	79.73	78.06	(1.67)
22	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	78.33	72.33	(6.00)

2.3. Соёлын индекс

ДШБҮ-г тооцооход ашигласан эхний үзүүлэлт нь соёлын индекс байна. Тус индексийг тооцохдоо **албан бус хэм хэмжээ** болон **авлигын эсрэг тогтолцоо** гэсэн хоёр дэд, 9 нэгж үзүүлэлтүүдийг (A1-A9 дугаартай)⁵ ашигласан. Албан бус хэм хэмжээг тухайн байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ авлига, хувийн ашиг сонирхлын шинжтэй үйлдлүүд гаргадаг эсэх талаарх асуултуудаар үнэлсэн. Харин байгууллагын авлигын дотоод хяналтын механизм, тогтолцооны талаарх асуултуудаар хоёр дахь дэд үзүүлэлтийг үнэлэв.

2025 онд төрийн байгууллагуудын соёлын индексийн дундаж үнэлгээ 75.56 болж өмнөх оноос 1.7 оноогоор өссөн. Үүнийг дэд үзүүлэлтүүдэд задлан харвал албан бус хэм хэмжээ ба авлигын эсрэг тогтолцооны үзүүлэлтүүд харгалзан 2.17 ба 1.23 оноогоор тус тус өсч үнэлэгджээ. Эдгээр хоёр дэд үзүүлэлтэд хамаарах 9 нэгж үзүүлэлтүүдээс 6 нэгж үзүүлэлт нэмэгдсэн бол 3 нь үзүүлэлт нь буурсан байна. Тэдгээрээс хамгийн их өсөлтийг үзүүлсэн асуултууд нь “төрийн алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг (A2)”, “танил талын нөлөөлөлд автдаг (A3)”, “бусдад дарамт шахалт үзүүлдэг (A4)” гэсэн асуултууд байна. Хавсралт 4-өөс соёлын индексийн 9 нэгж үзүүлэлтүүдийн оноо ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг харна уу. Үнэлгээний хандлагын хувьд соёлын индекс, түүний дэд үзүүлэлтүүдийг сүүлийн таван жилийн хугацаагаар доорх графикт харууллаа.

График 7. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор




⁵ үнэлгээний асуултуудыг **Хавсралт 1**-ээс харах боломжтой

График 77. -аас харахад соёлын индекс болон хоёр дэд үзүүлэлт нь 2021-2023 оны хооронд тогтмол өсч байсан бол 2024 онд буурч энэ жил дахин өсөн бөгөөд 2023 оны түвшинд хараахан хүрээгүй байгаа нь харагдаж байна.

Төрийн байгууллагын төрлөөр авч үзвэл яам, агентлаг ЗДТГ-уудын оноо эхний дэд үзүүлэлт болох албан бус хэм хэмжээ 2025 оны соёлын индексийн ерөнхий дундаж утгаас дээгүүр байгаа бол авлигын эсрэг тогтолцоо нь дундаас бага байна. Аймаг нийслэлийн Соёлын индекс, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс болон ДШБҮ индексүүд бусад төрлийн төрийн байгууллагын харгалзах индексүүдээс өндөр байгаа нь 8 дугаар графикаас харагдаж байна. Харин яамдын соёлын болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексүүд ДШБҮ-ний ерөнхий дундажтай ижил байгаа бол агентлагуудын соёлын индекс болон ДШБҮ-ний индекс ялимгүй бага байна.

График 8. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2025 он



Төрийн байгууллагуудын соёлын индексийн өөрчлөлтийн хувьд яамд 0.01 оноогоор буурсан бол агентлагууд болон ЗДТГ-ууд өмнөх оноос харгалзан 0.76 ба 4.45 оноогоор тус тус өсчээ.

2.3.1 Яамдын соёлын индексийн дүн

Яамдын соёлын индексийн хамгийн өндөр үнэлгээг Гадаад харилцааны яам 86.93 оноо авч үзүүлсэн бол Эрүүл мэндийн яам 61.42 оноогоор хамгийн бага үнэлгээ авсан бөгөөд өмнөх оноос 7.03 оноогоор буурсан байна (

Хүснэгт 9). Өмнөх оноос хамгийн өндөр өсөлттэй Батлан хамгаалах яам (14.53↑) соёлын индексийн дүнгээр яамдын дөрөвдүгээр байрт эрэмбэлэгдэж байгаа бол хамгийн ихээр буурсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (11.51↓) жагсаалтын 13 дугаарт үнэлэгдэж байна. Нийт 16 яамнаас 9 яамны соёлын индексийн үзүүлэлт сайжирсан бол 7 яамны соёлын индекс буурч үнэлэгджээ. Дээр дурдсан Батлан хамгаалах яам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хувьд дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр мөн адил хамгийн их ба хамгийн бага өөрчлөлтийн дүнгүүдийг харуулсан байгаа нь онцлог байна.

Хүснэгт 9. Яамдын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Соёлын индексийн үнэлгээ, 2025	Өөрчлөлт, оноогоор		
			Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Гадаад харилцааны яам	86.93	7.48	10.30	8.89
2	Сангийн яам	86.42	5.08	9.32	7.20
3	Эдийн засаг хөгжлийн яам	82.24	0.98	1.38	1.18
4	Батлан хамгаалах яам	81.90	17.20	11.86	14.53
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	78.76	0.52	4.34	2.43
6	Боловсролын яам	78.67	2.25	10.34	6.30
7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	76.94	2.97	6.26	4.61
8	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	75.34	0.18	1.34	0.76
9	Эрчим хүчний яам	74.92	(0.19)	0.39	0.10
10	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	74.11	(1.87)	(0.90)	(1.39)
11	Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам	74.11	(6.72)	(4.17)	(5.44)
12	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	73.77	(5.28)	(17.61)	(11.44)
13	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	71.03	(9.46)	(13.56)	(11.51)
14	Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	67.02	(2.89)	(4.12)	(3.50)
15	Зам, тээврийн яам	65.62	(5.02)	(6.79)	(5.90)
16	Эрүүл мэндийн яам	61.42	(4.88)	(9.18)	(7.03)
Яамдын дундаж		75.57	0.02	(0.05)	(0.01)

2.3.2 Агентлагуудын соёлын индексийн дүн

Агентлагуудын 2025 оны соёлын индексийн дүн ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтүүдийг дараах хүснэгтэд харуулав. Нийт 34 агентлагаас 17 нь соёлын индексийн үнэлгээг өмнөх оноос сайжруулсан бол үлдсэн 17 агентлагийн үнэлгээ буурсан. Соёлын индексээр тэргүүлж буй Оюуны өмчийн газар, Боловсролын ерөнхий газрууд ДШБҮ-ийн дүнгээр харгалзан 72 байгууллагаас 1, 2 дугаарт эрэмбэд багтсан бол Мал эмнэлгийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Цаг уур орчны шинжилгээний газрууд мөн л нийт эрэмбийн сүүлийн таван байрт эрэмбэлэгдсэн. Дурдсан сүүлийн гурван байгууллагаас Цаг уур, орчны шинжилгээний газрын соёлын индекс хэдийгээр бага гарсан боловч өнгөрсөн жилээс өсөлттэй байсан бол Мал эмнэлгийн ерөнхий газрын соёлын индексийн дэд үзүүлэлтүүд 19-өөс их оноогоор буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын соёлын индексийн үзүүлэлтэд өөрчлөлт бага байгаа нь өмнөх онд ч мөн доогуур үнэлгээ авч байсныг илтгэнэ.

Оюуны өмчийн газар (15.61↑), Биеийн тамир, спортын улсын хороо (15.61↑), Үндэсний геологийн алба (13.83↑), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (15.61↑) -уудын соёлын индекс ба дэд үзүүлэлтүүдийн өсөлт хамгийн өндөр байсан бөгөөд Цаг уур, орчны шинжилгээний газар, Биеийн тамир, спортын улсын хороо хоёроос бусад нь соёлын индексийн үнэлгээгээр агентлагуудыг тэргүүлж байна. Соёлын индексээр эхний байруудад эрэмбэлэгдсэн байгууллагуудын дэд индексүүд нь бүгд өмнөх оноос өсөлттэй гэрчээ.

Соёлын индекс ба бүх дэд үзүүлэлтүүд бууралттай Мал эмнэлгийн ерөнхий газар хамгийн бага үнэлгээтэй байгаа бол эрэмбийн 53-т жагсаж байгаа Цаг уур, орчны шинжилгээний газрын авлигын эсрэг тогтолцоо дэд үзүүлэлт өсөлттэй гарч соёлын индексийн өсөлтийг нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 10. Агентлагуудын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Соёлын индексийн үнэлгээ	Өөрчлөлт, оноогоор		
			Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Оюуны өмчийн газар	98.04	9.08	22.14	15.61
2	Боловсролын ерөнхий газар	88.01	4.16	8.77	6.47
3	Усны газар	87.04	2.61	12.43	7.52
4	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	87.03	6.03	16.81	11.42
5	Онцгой байдлын ерөнхий газар	82.09	4.69	8.23	6.46
6	Жижиг, дунд үйлдвэрийн газар	81.54	(8.34)	(1.44)	(4.89)
7	Шүүх шинжилгээний ерөнхий газар	80.47	3.28	3.77	3.53
8	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	80.46	0.58	6.08	3.33
9	Цагдаагийн ерөнхий газар	79.84	(2.88)	(2.39)	(2.63)
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	79.76	(1.54)	3.67	1.06
11	Гадаадын иргэн харьяатын газар	79.55	0.90	(2.19)	(0.65)
12	Татварын ерөнхий газар	79.48	0.16	2.76	1.46
13	Биеийн тамир, спортын улсын хороо	78.75	17.23	22.13	19.68
14	Стандарт, хэмжил зүйн газар	78.68	1.07	(3.32)	(1.12)
15	Монополын эсрэг газар	78.24	(3.52)	6.06	1.27
16	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	78.15	0.05	(3.88)	(1.91)
17	Улсын бүртгэлийн ерөнхий газар	78.11	(0.83)	(0.45)	(0.64)
18	Төрийн худалдан авах ажиллагааны газар	77.57	11.32	11.48	11.40
19	Үндэсний геологийн алба	77.53	22.48	5.30	13.89
20	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	74.40	(2.55)	(6.76)	(4.65)
21	Соёл урлагийн газар	74.36	(2.28)	4.56	1.14
22	Нийгмийн даатгалын ерөнхий газар	74.34	(4.66)	(4.05)	(4.35)
23	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	71.66	(4.74)	(9.49)	(7.12)
24	Архивын ерөнхий газар	71.41	3.78	9.19	6.49
25	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	70.82	(8.88)	(2.52)	(5.70)
26	Иргэний нисэхийн ерөнхий газар	69.72	(0.34)	(3.69)	(2.02)
27	Ашигт малтмал, газрын тосны газар	67.99	8.44	6.88	7.66
28	Гаалийн ерөнхий газар	67.15	(4.38)	(7.52)	(5.95)
29	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	65.19	(9.90)	(13.58)	(11.74)
30	Ойн газар	64.23	(5.86)	(8.26)	(7.06)
31	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	63.73	(1.39)	(2.98)	(2.19)
32	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	61.53	(10.55)	(24.74)	(17.64)
33	Цаг уур, орчны шинжилгээний газар	57.12	(0.32)	22.65	11.16
34	Мал эмнэлгийн ерөнхий газар	46.35	(19.83)	(26.72)	(23.28)
Агентлагуудын дундаж		75.01	0.09	1.44	0.76

Цаг уур, орчны шинжилгээний газар нь ДШБҮ-ий дүнгээр мөн хамгийн сүүлд эрэмбэлэгдэж байгаа болон нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар өмнөх 2.1 хэсэгт тайлбарласан. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хувьд төрийн албан хаагч үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг (A1) эсэхэд 57 оноо, авлига, ашиг сонирхлын талаарх шүгэл үлээгчийг бүрэн хамгаалсан (A7) эсэхэд 50 оноо, авлигын зөрчилд хариуцлага тооцдог (A8) эсэхэд 58 оноо, авлигыг хянах, дотоод хяналтын механизм бүрдсэн (A9) эсэхэд 48 өгсөн байгаа нь цаашид анхаарах асуудал болж байна. Албан бус хэм хэмжээ, авлигын эсрэг тогтолцооны индексийн хамгийн ихээр буурсан Мал эмнэлгийн ерөнхий газрын холбогдох нэгж үзүүлэлтүүдийг харвал дийлэнх үзүүлэлтэд 60-аас доош оноо өгсөн байна.

Соёлын индекс өмнөх оноос хамгийн их өсөлт үзүүлсэн болон хамгийн их өөрчлөгдсөн агентлагуудыг доорх графикт харууллаа.

График 9. Соёлын индекс хамгийн их өөрчлөгдсөн эхний болон сүүлийн таван агентлаг



Графикаас харахад хэдийгээр дундаас хойш эрэмбэлэгдэж байгаа боловч өсөлтөөр тэргүүлж байгаа агентлагууд байна. Тухайлбал, Үндэсний геологийн алба 19 дүгээр байрт эрэмбэлэгдэж байсан бол өсөлт өндөр таван агентлагийн нэгээр үнэлэгдсэн байна.

2.3.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индексийн дүн

2025 оны судалгаагаар аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индекс бусад төрлийн байгууллагуудтай харьцуулахад хамгийн их өссөн буюу өмнөх онтой харьцуулахад 4.45 оноогоор өндөр үнэлэгдсэн. Яам, агентлагуудын үзүүлэлттэй харьцуулахад аймгуудын ЗДТГ-ын соёлын индексийн холбогдох дэд үзүүлэлтүүд өмнөх оноос 10-аас дээш оноогоор өссөн тохиолдол олон байна. Мөн авлигын эсрэг тогтолцооны үзүүлэлтийн өөрчлөлтөөс харахад 10-аас дээш оноогоор өсөж үнэлэгдсэн байгууллагууд ч мөн цөөнгүй байна.

Хөвсгөл, Увс аймгуудын ЗДТГ нь ДШБҮ-ний дүнгээр нийт 72 байгууллагын 6 болон 8 дугаар байрт буюу аймгийн ЗДТГ-уудаас дээгүүр эрэмбэлэгдэж байсан бол соёлын индексийн хувьд мөн ЗДТГ-уудыг тэргүүлж байна. Нөгөө талаас Хэнтий ба Баян-Өлгий аймгууд ДШБҮ-ээр болон соёлын индексээр сүүлийн байруудад бичигдсэн байна. Увс, Сүхбаатар, Дархан-Уул, ба Хөвсгөл аймгуудын ЗДТГ байгууллагын авлигын эсрэг тогтолцоо, түүний үйл ажиллагаанд анхаарч ажилласнаар үнэлгээг өсгөж чадсан байгаа бол Ховд, Өмнөговь, Хэнтий, Дундговь аймгуудын ЗДТГ алба хаагчид нь ажил үүргээ гүйцэтгэхдээ шударга, ашиг сонирхлын зөрчил, дарамт, нөлөөллөөс ангид ажиллах соёлын хэм хэмжээг бүрдүүлж ажилласан нь харагдаж байна.

Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Соёлын индексийн үнэлгээ	Өөрчлөлт, оноогоор		
			Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Хөвсгөл аймгийн ЗДТГ	89.77	15.57	11.32	13.44
2	Увс аймгийн ЗДТГ	83.59	10.34	21.35	15.84
3	Дорноговь аймгийн ЗДТГ	83.05	4.56	2.41	3.48
4	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	82.54	1.26	(3.74)	(1.24)

5	Архангай аймгийн ЗДТГ	81.35	2.79	7.31	5.05
6	Дархан-Уул аймгийн ЗДТГ	81.20	2.63	16.21	9.42
7	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	78.11	9.71	0.84	5.28
8	Орхон аймгийн ЗДТГ	78.05	(0.53)	(1.04)	(0.79)
9	Булган аймгийн ЗДТГ	77.98	(2.69)	(7.93)	(5.31)
10	Баянхонгор аймгийн ЗДТГ	77.55	(4.59)	(12.67)	(8.63)
11	Төв аймгийн ЗДТГ	75.76	(3.50)	(6.01)	(4.76)
12	Говь-Алтай аймгийн ЗДТГ	75.56	(2.70)	(4.22)	(3.46)
13	Өмнөговь аймгийн ЗДТГ	75.20	26.57	(6.35)	10.11
14	Дорнод аймгийн ЗДТГ	75.10	4.54	9.36	6.95
15	Өвөрхангай аймгийн ЗДТГ	74.34	4.69	(0.84)	1.93
16	Дундговь аймгийн ЗДТГ	74.18	15.85	2.19	9.02
17	Сүхбаатар аймгийн ЗДТГ	73.98	13.33	16.41	14.87
18	Ховд аймгийн ЗДТГ	70.91	41.88	10.70	26.29
19	Нийслэлийн ЗДТГ	69.88	(4.25)	(0.13)	(2.19)
20	Завхан аймгийн ЗДТГ	68.43	(0.30)	3.94	1.82
21	Хэнтий аймгийн ЗДТГ	68.05	19.53	(15.49)	2.02
22	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	66.09	0.37	(3.07)	(1.35)
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд		76.39	7.05	1.84	4.45

Соёлын индексийн хоёр дэд үзүүлэлт бууралттай, үнэлгээ нь доогуур байгаа Баянхонгор, Төв, Булган зэрэг аймгуудын ЗДТГ дахь авлига, шударга байдалтай холбогдох соёлын хэм хэмжээг сайжруулж, дүрэм, журмыг мөрдүүлж ажиллахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Өмнөх хэсэгт дурдаагүй Булган аймгийн **авлигын эсрэг тогтолцооны** үзүүлэлтийн огцом бууралтын шалтгааныг авч үзвэл “авлига ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээллийг хамгаалах (A7)”, “авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг (A8)”, “авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдсэн (A9)” зэрэг нэгж асуултуудад өмнөх жил 76.9 оноо авч байсан бол 2025 оны судалгаагаар дунджаар 61 оноо авсан нь нөлөөлж байна.


2.4. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

ДШБҮ-ний тооцоололд ашиглагдаж буй хоёр дахь индекс нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс байна. Энэ индексийг тооцоход **хүний нөөц, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, удирдлагын хүсэл, эрмэлзэл** зэрэг 5 дэд үзүүлэлт, 17 нэгж асуултын үр дүнг (A10-A26 дугаартай) ашигласан.

2025 онд төрийн байгууллагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дундаж үнэлгээ 89.26 болж өмнөх оноос 0.07 оноогоор буурсан байна. Тус индексийн бүрэлдэхүүн дэд үзүүлэлтүүдийн гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал, удирдлагын хүсэл эрмэлзэл гэсэн хоёр үзүүлэлт нэмэгдэж, хүний нөөц, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексүүдэд өөрчлөлт ороогүй бол үлдсэн хоёр үзүүлэлт болох төсвийн зориулалтын бус зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдлын үнэлгээний үзүүлэлтүүд буурч үнэлэгдсэн байна. Эдгээрээс хамгийн их өөрчлөлттэй нь төсвийн зарцуулалт дэд үзүүлэлт өмнөх оноос 1.4 оноогоор буурч 92.23 оноогоор үнэлэгдсэн байна. Энэ онд удирдлагын хүсэл эрмэлзлийг илэрхийлэх үзүүлэлт мөн бусад үзүүлэлтүүдээс хамгийн багаар үнэлэгдсэн хэвээр байна. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн тооцоололд ашиглаж буй нэгж үзүүлэлтүүдээс өмнөх онтой харьцуулахад хамгийн их буурсан асуулга нь “төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал, ба зарцуулалтын хэмжээ, давтамжийг тодорхойлсон асуултууд (A14-A15.2)”, “удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх (A18)”, “албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх (A10)”


зэрэг асуудлууд байв. Хавсралт 5-өөс үүргээ шударгаар биелүүлэх байдлын индексийн 19 нэгж үзүүлэлтүүдийн оноо ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг харна уу.

График 10. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзэхэд өмнөх оны үр дүнгээс бага зэрэг буурсан байна. Тухайлбал яамдын хувьд удирдлагын хүсэл эрмэлзлээс бусад дэд үзүүлэлтүүд буурсан нь тус индексийг 0.72 оноогоор бууруулсан бол ЗДТГ-ууд 0.04 буурчээ. Харин агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын дундаж 0.23 оноогоор өссөн. Дэд үзүүлэлтүүдээс төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал гэсэн дэд үзүүлэлт хамгийн ихээр буурсан бол гадаад орчин дахь авлигатай тэмцэх, удирдлагын хүсэл эрмэлзэл гэсэн үзүүлэлтүүд өмнөх оноос өсчээ. Харин 6 дэд үзүүлэлтийг байгууллагуудаар нь авч үзвэл ДШБҮ-ийн дэд үзүүлэлтүүд бага зэрэг өөрчлөгдсөн (өссөн) байгаа нь доорх графикаас харагдаж байна. Мөн түүнчлэн хүний нөөцийн дэд үзүүлэлтийн тухайд яамдынх бусад төрлийн төрийн байгууллагуудаас харьцангуй их байгаа бол төсвийн зарцуулалтын дэд үзүүлэлтээр ЗДТГ-ын дэд үзүүлэлт бусдаасаа өндөр байна. Гадаад орчин дахь авлигатай тэмцэх, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс гэсэн дэд үзүүлэлтүүдийн хувьд төрийн байгууллагуудын хувьд ижил үнэлэгдсэн байна.

График 11. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр



2.4.1 Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн

Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн хамгийн өндөр үнэлгээг Сангийн яам авсан бол хамгийн бага үнэлгээг мөн л Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тус тус авсан байна. Өмнөх онд хамгийн багаар үнэлэгдэж байсан Батлан хамгаалах яам тухайн индексээр энэ жил хамгийн өндөр өсөлттэй байлаа. Харин үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хамгийн ихээр буурсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам өнгөрсөн жилээс 11.27 оноогоор буурч хамгийн сүүлд жагссан байна. Нийт 16 яамдаас 10 яамны индекс өмнөх оны судалгаанаас буурсан бол 6 яамны индекс өссөн нь ерөнхий дундаж үзүүлэлтээр өмнөх оноос 1.16 оноогоор буурч үнэлэгджээ. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд бүх дэд үзүүлэлтээр хамгийн их бууралттай байгаа нь соёлын индексийн өөрчлөлтийн үр дүнтэй адил байна.

Хүснэгт 12. Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	(0.85)	16.24	2.49	1.00	1.53	4.08
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	0.61	(1.13)	(0.91)	(3.33)	(2.46)	(1.44)
3	Батлан хамгаалах яам	14.68	16.22	15.47	6.67	10.13	12.64
4	Боловсролын яам	(9.91)	4.34	1.33	-	(1.09)	(1.06)
5	Гадаад харилцааны яам	(7.75)	(2.34)	0.28	(4.00)	11.37	(0.49)
6	Зам, тээврийн яам	(3.25)	(1.13)	(3.81)	-	(6.90)	(3.02)
7	Сангийн яам	1.80	0.37	4.97	1.00	4.43	2.52
8	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	(0.18)	(10.29)	(13.87)	-	4.00	(4.07)
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	0.07	(0.66)	(1.31)	-	5.68	0.76

10	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	(16.13)	(9.10)	(10.38)	(4.00)	(1.22)	(8.17)
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	(0.47)	(2.46)	1.11	1.00	6.50	1.14
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	(21.28)	(1.18)	0.00	-	4.14	(3.66)
13	Эрүүл мэндийн яам	0.11	(11.67)	(7.98)	(1.00)	(9.81)	(6.07)
14	Эрчим хүчний яам	(1.80)	(0.56)	2.49	-	6.43	1.31
15	Эдийн засаг хөгжлийн яам	0.03	(3.16)	(2.80)	-	0.41	(1.10)
16	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	0.86	(5.64)	(10.02)	-	(9.82)	(4.92)
Яамдын дундаж		(2.72)	(0.76)	(1.43)	(0.17)	1.46	(0.72)

2.4.2 Агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн

Дараах хүснэгтэд агентлагуудыг үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн оноогоор жагсааж, түүнд хамаарах дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харуулав. 2025 онд 17 агентлагийн үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн өсч, 17 байгууллагынх буурсан байна. Уг индексийн оноогоор агентлагуудыг эрэмбэлэхэд хамгийн өндөр үнэлгээ авсан агентлаг нь Биеийн тамир, спортын улсын хороо байсан бол хамгийн бага дүнтэй агентлаг нь өмнөх соёлын индексийн эрэмбэтэй адил байна. Энэ нь эдгээр хоёр индекс хоорондоо хамааралтай буюу соёлын хэм хэмжээ, авлигын эсрэг тогтолцоог сайн бүрдүүлсэн байгууллагууд төдий чинээ хүний нөөц, төсөв, үүргээ биелүүлэх, гадаад орчин дахь авлигатай тэмцэх, авлигын эсрэг удирдлагын хүсэл эрмэлзэл өндөр байх боломжтой гэсэн таамаглал дэвшүүлэхэд хүргэж байна.

Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексээр 2025 онд Биеийн тамир, спортын улсын хороо (26.41↑), Цаг уур, орчны шинжилгээний газрууд (22.22↑) хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бол 10-оос дээш оноогоор буурсан таван агентлаг байна. Хамгийн тааруу үр дүн үзүүлсэн агентлагуудаас Мал эмнэлгийн ерөнхий газрыг авч үзвэл ихэнх дэд үзүүлэлт буурсны дотор Төсвийн зарцуулалт үнэлгээ (35.15↓), Авлигатай тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзэл (18.76↓) оноогоор тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. Агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	(0.26)	1.99	2.20	-	1.79	1.14
2	Онцгой байдлын ерөнхий газар	2.55	11.52	4.86	-	8.93	5.57
3	Монополын эсрэг газар	-	0.60	8.09	-	5.56	2.85
4	Стандарт, хэмжил зүйн газар	(0.90)	3.52	4.33	3.00	4.93	2.97
5	Цаг уур, орчны шинжилгээний газар	23.17	17.80	30.47	15.00	26.64	22.62
6	Гаалийн ерөнхий газар	(2.63)	(14.89)	(4.10)	-	0.24	(4.28)
7	Татварын ерөнхий газар	(0.05)	(0.24)	(2.39)	1.00	(5.85)	(1.51)
8	Цагдаагийн ерөнхий газар	(4.78)	(1.55)	(0.99)	(2.00)	(4.18)	(2.70)
9	Улсын бүртгэлийн ерөнхий газар	0.23	5.05	(5.93)	1.00	(2.19)	(0.37)
10	Архивын ерөнхий газар	(0.74)	21.04	0.35	(3.33)	(3.90)	2.68

11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.17	2.99	2.08	2.00	2.81	2.01
12	Гадаадын иргэн харьяатын газар	(15.10)	(0.08)	(4.28)	(1.00)	(0.78)	(4.25)
13	Нийгмийн даатгалын ерөнхий газар	0.14	1.56	(3.16)	-	(0.83)	(0.46)
14	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	(1.49)	(19.92)	(13.29)	-	(5.28)	(8.00)
15	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	(1.25)	(8.46)	(11.83)	-	(17.79)	(7.86)
16	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	1.18	(1.01)	4.88	-	4.76	1.96
17	Биеийн тамир, спортын улсын хороо	44.38	25.31	17.77	18.33	26.64	26.49
18	Соёл урлагийн газар	(7.76)	(0.33)	(33.23)	-	(5.12)	(9.29)
19	Иргэний нисэхийн ерөнхий газар	0.84	(3.90)	(4.07)	(1.00)	1.73	(1.28)
20	Ашигт малтмал, газрын тосны газар	12.98	3.00	3.89	-	8.40	5.65
21	Мал эмнэлгийн ерөнхий газар	0.30	(21.93)	(42.97)	(5.00)	(18.76)	(17.67)
22	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	0.52	(0.15)	(1.12)	-	(6.62)	(1.47)
23	Оюуны өмчийн газар	1.08	0.49	6.56	-	13.83	4.39
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	0.22	(55.66)	(3.00)	-	(7.06)	(13.10)
25	Төрийн худалдан авах ажиллагааны газар	2.27	3.08	6.34	2.50	0.71	2.98
26	Усны газар	0.05	2.56	(2.68)	-	0.62	0.11
27	Үндэсний геологийн алба	8.08	8.09	9.72	-	29.12	11.00
28	Жижиг, дунд үйлдвэрийн газар	(3.36)	(28.47)	(10.93)	(5.00)	(13.37)	(12.22)
29	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	0.28	1.38	(14.93)	(5.00)	(3.20)	(4.29)
30	Боловсролын ерөнхий газар	0.66	1.25	0.91	-	8.91	2.35
31	Ойн газар	(1.33)	14.12	0.82	-	(7.22)	1.28
32	Шүүх шинжилгээний ерөнхий газар	(5.65)	(2.72)	10.86	(1.67)	6.89	1.54
33	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	(0.09)	0.58	3.76	-	12.96	3.44
34	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	(0.39)	(3.23)	(11.46)	-	(7.54)	(4.52)
Агентлагуудын дундаж		1.57	(1.08)	(1.54)	0.55	1.64	0.23

2.4.3 Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн

Өмнөх онд 9 аймгийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс өссөн бол энэ онд 11 болж нэмэгдсэн байна. Эдгээрээс Ховд, Өвөрхангай аймгуудын аймгийн ЗДТГ-уудын индекс хамгийн их өсөлттэй байсан бол Баян-Өлгий, Төв аймгуудын индекс 10-аас дээш оноогоор буурч үнэлэгджээ. Энэхүү үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь соёлын индексээс Ховд аймаг ижил, Төв аймаг ойролцоо байсан бол Өвөрхангай, Баян-Өлгий аймгуудынх ихээхэн зөрүүтэй байна. ДШБҮ-ний дүнгээр төрийн байгууллагуудын тавд, соёлын индексийн дүнгээр дөрөвт бичигдэж байгаа Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн өөрчлөлт анхаарал татахуйц байна. Тус аймаг соёлын индексийн дэд үзүүлэлтүүд 10-аас дээш оноогоор өсөлттэй үнэлэгдсэн бол үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын дэд үзүүлэлтүүдийн төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, удирдлагын хүсэл эрмэлзэл гэсэн дэд үзүүлэлтүүд бага зэрэг өссөн боловч бусад үзүүлэлтүүд нь өмнөх онтой харьцуулахад буурсан нь харагдаж байна.

Мөн түүнчлэн Баянхонгор, Өмнөговь, Хэнтий зэрэг аймгуудын соёлын индекс, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексүүд ихээхэн зөрүүтэй үнэлэгдсэн байгааг судалгаа харуулж байна. Ихэнх аймгуудын ЗДТГ-ын хоёр индексийн зөрүү 10-аас дээш оноо байгаа нь удирдах албан тушаалтны шударга байдал, тухайн байгууллага нь дахь

шударга байдал харилцан адилгүй байгааг харуулж байна. Тамгын газруудын хувьд гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал өмнөх оноос өөрчлөлт бага боловч илүү сайжирсан байна.

Хүснэгт 14. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллага	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Ховд аймгийн ЗДТГ	6.13	(0.60)	5.95	26.67	3.52	8.33
2	Өвөрхангай аймгийн ЗДТГ	(1.11)	1.88	36.64	-	(5.91)	6.30
3	Дундговь аймгийн ЗДТГ	2.86	(3.54)	3.41	6.67	20.06	5.89
4	Завхан аймгийн ЗДТГ	6.25	(0.02)	13.46	1.67	1.70	4.61
5	Дархан-Уул аймгийн ЗДТГ	(0.32)	1.29	5.60	5.00	8.30	3.97
6	Сүхбаатар аймгийн ЗДТГ	3.47	(8.90)	(4.33)	18.33	9.47	3.61
7	Увс аймгийн ЗДТГ	1.51	(1.36)	4.97	-	8.30	2.68
8	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	1.26	(0.19)	0.99	3.33	3.55	1.79
9	Архангай аймгийн ЗДТГ	2.32	0.77	(1.95)	-	4.77	1.18
10	Баянхонгор аймгийн ЗДТГ	5.72	5.42	(0.30)	3.33	(10.58)	0.72
11	Хөвсгөл аймгийн ЗДТГ	(2.02)	1.15	3.07	(3.33)	1.32	0.04
12	Нийслэлийн ЗДТГ	(0.10)	2.22	(5.08)	(1.88)	4.26	(0.12)
13	Дорнод аймгийн ЗДТГ	(0.91)	(2.56)	(0.44)	-	2.14	(0.35)
14	Булган аймгийн ЗДТГ	0.33	(0.88)	(7.65)	8.33	(4.54)	(0.88)
15	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	0.83	0.10	1.35	-	(6.81)	(0.91)
16	Орхон аймгийн ЗДТГ	(1.30)	(1.80)	(3.39)	-	1.79	(0.94)
17	Өмнөговь аймгийн ЗДТГ	(2.83)	(7.07)	4.20	-	(2.20)	(1.58)
18	Дорноговь аймгийн ЗДТГ	(0.19)	(2.17)	(2.73)	-	(3.34)	(1.68)
19	Хэнтий аймгийн ЗДТГ	0.18	(4.02)	(3.24)	-	(19.73)	(5.36)
20	Говь-Алтай аймгийн ЗДТГ	(1.60)	(21.63)	(11.84)	-	(1.30)	(7.28)
21	Төв аймгийн ЗДТГ	(28.81)	(5.74)	(4.67)	-	(12.10)	(10.26)
22	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	(1.57)	(4.70)	(30.05)	-	(16.95)	(10.65)
ЗДТГ		(0.45)	(2.38)	0.18	3.10	(0.65)	(0.04)

2.4.4 Чанарын асуултуудын үр дүн


Үүргээ шударгаар гүйцэтгэх индексийн үнэлгээний хүрээнд үнэлгээний оноонд тооцогдохгүй, чанарын болон нээлттэй асуултуудыг албан хаагчдаас асуусан ба үр дүнг дараах хэсэгт харуулав.

Төрийн албан хаагчдаас сүүлийн 12 сарын хугацаанд албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгсөн тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 20 хүн буюу 1 хувь нь “тийм” гэж хариулжээ. Дээр дурдсан зүйлсийг өгөх болсон шалтгааныг тодруулахад давуу байдал олж авахаар болон бусад шалтгаанаар гэж тус бүр 18 хувь нь хариулсан бол 9 хувь нь уламжлал болсон учраас, 14 хувь нь удирдах албан тушаалтны хүсэлтээр, 41 хувь нь талархлаа илэрхийлэхээр гэж хариулсан байна.

Харин сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 96 хариулт буюу

нийт судалгаанд оролцогчдын 4 хувь нь “тийм” гэж хариулсан нь 2024 онтой харьцуулахад 1.5 пунктээр нэмэгдсэн байна. Хариултыг төрийн байгууллагуудын төрлөөр ангилж харвал тийм гэсэн хариултын 40 хувь агентлагт, 30 хувь нь аймаг, нийслэлийн ЗДТГ-т, үлдсэн 30 хувь нь яамдад хамаарч байна. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгааныг тодруулахад 46 хувь нь удирдах албан тушаалтны шийдвэрээр, 15 хувь нь хяналт сул байдаг, 8 хувь нь бусад байгууллага, хүний шахалтаар, 15 хувь нь уламжлал болсон учраас, 13 хувь нь ёс зүй хариуцлагатай байдал дутсанаас, 4 хувь нь бусад хэмээн тус тус хариулжээ.

График 12. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан



Удирдах албан тушаалтны шийдвэрээр төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон хариултын хувь өмнөх оноос буурсан байна. Энэ төрлийн шалтгаан жил бүр дийлэнх хувийг бүрдүүлж байгаа явдал, мөн ДШБҮ-ний үнэлгээнд хамгийн бага оноотой дэд үзүүлэлт нь удирдлагын хүсэл эрмэлзэл байгаа зэрэг нь тухайн байгууллагын шударга байдлыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд удирдах албан тушаалтны санаачлаг, үүрэг, хариуцлага чухал байгааг харуулж байна.

Мөн албан хаагчдаас танай байгууллага дахь шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд нэн тэргүүнд юу хийх шаардлагатай талаарх асуултад хамгийн өндөр давтамжтай гурван хариулт нь ажлын байрны чиг үүргийг тодорхой болгож, давхардлыг бууруулах - 39 хувь, цалин хангамж, орлогыг нэмэгдүүлэх – 16 хувь, хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйтэй иргэн бэлтгэх – 9 хувь зэрэг зүйлс байсан ба эдгээр хариултууд өмнөх оны үнэлгээнд ч мөн давтамжтай ихтэй байсан байна. Үүнээс дүгнэхэд эдгээр хүчин зүйлс нь авлигаас сэргийлэхэд байгууллагад хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа хэвээр байсаар байна. Харин мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нь авлига буурах гол шалтгаан болохыг өмнөх жилүүдийн хариултуудад өгч байсан бол энэ жил тухайн хариултыг хариулсан тоо огцом буурсан байгаа нь мэдээллийг ил тод байдал хангагдаж, мэдээлэл цахимжсан болохыг илтгэнэ.

Хүснэгт 15. Байгууллагын шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний саналын нэгтгэл

№	Хариултын утга	Нийт хариултад эзлэх хувь
1	Ажлын байрны чиг үүргийг тодорхой болгож давхардлыг бууруулах	39%
2	Цалин хангамж, орлогыг нэмэгдүүлэх,	16%
3	Хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйтэй иргэдийг бий болгох	9%
4	Цахим үйлчилгээ нэвтрүүлж, хүний оролцоог багасгах	5%
5	Төрийн алба хаагч хариуцлагатай байх	4%
6	Танил тал, хамаатан садны холбоо	4%
7	Ажлын шат дамжлагыг багасгах	3%
8	Ашиг сонирхлын зөрчлийг арилгадаг байх	3%
9	Авлига ашиг сонирхлыг талаар хийх, хуулийн мэдээллээр хангах	2%
10	Улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах	2%
11	Ажиллах орчин сайжруулах	2%
12	ТАХ-ын ажлын ачааллыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх	1%
13	Хариуцлага тооцдог байх	1%
14	Ажилтантай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийх	1%
15	Тогтолцоо буруу (Улс төр, засаглал, авлигын сүлжээ зэргийг тогтолцооны хувьд засах)	1%
16	АТГ мэдээлэл өгсөн хүнийг нууцлах, авсан хүнийг шийтгэх, мэдээлэл өгөх тогтолцоог бий болгох	1%
17	Иргэдийн боловсролыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх	1%
18	Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах	1%

2.5 Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ

2022 оноос төрийн байгууллагын ДШБҮ-ийн үнэлгээнд дүүргүүдийн ЗДТГ-ыг хамруулж эхэлсэн. Өмнөх оны үнэлгээний мэдээллийн харьцуулагдах боломжийг хангах үүднээс төрийн байгууллагуудын ДШБҮ болон түүний дэд үзүүлэлтүүдийн дундаж тооцоонд дүүргийн үнэлгээний утгуудыг оруулаагүй болно. Тиймээс энэ дэд хэсэгт 9 дүүргийн ЗДТГ-ын ДШБҮ ба бүрэлдэхүүн индексийн үнэлгээний дүнг тоймлов.

2025 онд дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ-ний дундаж 82.05 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 2 оноогоор буурсан боловч бусад төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ-тэй ойролцоо үнэлэгджээ. Дүүргүүдээс Хан-Уул ба Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хамгийн өндөр үнэлгээг авсан бол Багахангай ба Баянгол дүүргийн ЗДТГ-ууд хамгийн бага үнэлгээг авчээ. 2025 онд хоёр дүүргийн ДШБҮ өссөн бол бусад 7 дүүргийн үнэлгээ өмнөх оноос буурч үнэлэгдсэн байна. Эдгээрээс өсөлттэй хоёр дүүрэг нь Багануур болон Хан-Уул дүүргийн ЗДТГ-ууд байсан бол хамгийн их буурсан нь Багахангай, Баянгол дүүргийн ЗДТГ-ууд байна. Баянгол дүүргийн ЗДТГ-ын ДШБҮ-ний гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдлаас бусад бүх дэд үзүүлэлтүүд 7-оос дээш оноогоор буурсан байна. Дүүргүүдийн ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүдээс гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал өөрчлөлт бараг байхгүй байгаа бол үүрэг даалгаврын шударга байдал, төсвийн зарцуулалт гэсэн дэд үзүүлэлтүүд хамгийн ихээр буурч өөрчлөгдсөн байна.


ДШБҮ-ний хамгийн их өссөн Багануур дүүргийн ЗДТГ-ын соёлын индекс 9.45 оноогоор өссөн бол үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 0.91 оноогоор өмнөх оноос буурчээ.

Хүснэгт 16. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, 2023-2025 он

Дүүргүүд	2023	2024	2025
Хан-уул дүүргийн ЗДТГ	80.4	85.2	89.06
Сүхбаатар дүүргийн ЗДТГ	86.7	87.4	85.57
Багануур дүүргийн ЗДТГ	84.6	80.8	85.20
Налайх дүүргийн ЗДТГ	86.7	83.4	82.99
Баянзүрх дүүргийн ЗДТГ	85.6	85.9	81.18
Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	82	84.3	81.11
Чингэлтэй дүүргийн ЗДТГ	82.9	81	80.15
Багахангай дүүргийн ЗДТГ	81.9	86.6	79.71
Баянгол дүүргийн ЗДТГ	89.5	81.8	75.03
Дүүргийн дундаж	84.48	84.04	82.22

Дүүргүүдийн ДШБҮ-г соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн хувьд харьцуулан дараах графикт харуулав. Дүүргүүдийн соёлын индексийн дундаж нь 75.08, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дундаж нь 89.01 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос харгалзан 1.28 болон 2.75 онооны бууралтыг тус тус үзүүлсэн байна. Соёлын индекс энэ онд ч мөн багаар үнэлэгдсэн нь ЗДТГ-ын ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдлыг эрхэмлэх, хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавих эсэх, бусдын нөлөөнд автахгүй, бусдыг дарамт шахалтад оруулахгүй байх, авлигын эсрэг дотоод тогтолцоо, механизмын үр дүнтэй байдал зэрэг байгууллагад тогтсон холбогдох соёлын хэм хэмжээ хангалтгүй түвшинд байсаар байгааг илэрхийлнэ.

График 13. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд үзүүлэлтээр, дүүрэг тус бүрээр



Дараах хүснэгтэд соёлын индекс, түүний дэд үзүүлэлтүүдийг дүүргүүдээр задлан харуулав. Дүүргүүдийн дундаж албан бус хэм хэмжээ өмнөх оноос 1.95 оноогоор, авлигын эсрэг тогтолцоо өмнөх оноос 0.62 оноогоор тус тус буурсан байна. Авлигын эсрэг тогтолцоо өмнөх онуудтай адил бага үнэлэгдсэн хэвээр бөгөөд дүүргүүдийн дундаж үнэлгээнээс харахад авлигын зөрчлийг мэдээлэгчийн хамгаалсан байдалд 70 оноо, зөрчилд хариуцлага тооцдог байдалд 75, авлигын эсрэг дотоод механизм бүрдсэн байдалд 66 оноог тус тус өгсөн байна.

Хүснэгт 17. Дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын индекс, дэд үзүүлэлтээр, 2025

№	Байгууллагын нэр	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	87.28	80.19	83.73
2	Багануур дүүргийн ЗДТГ	87.12	73.72	80.42
3	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	84.01	72.97	78.49
4	Налайх дүүргийн ЗДТГ	79.10	73.96	76.53
5	Баянзүрх дүүргийн ЗДТГ	81.24	70.68	75.96
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	78.08	69.52	73.80
7	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	75.92	65.26	70.59
8	Багахангай дүүргийн ЗДТГ	74.67	65.92	70.30
9	Баянгол дүүргийн ЗДТГ	72.96	58.85	65.91
Дундаж үнэлгээ		80.04	70.12	75.08

Дүүргүүдийн үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн нэгж үзүүлэлтүүдээс удирдлагын хүсэл эрмэлзэл хамгийн их оноогоор 2.75 оноогоор буурсан үзүүлэлт болсон байна. Харин гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдлын дэд үзүүлэлт өмнөх оноос хамгийн багаар буурсан. Цаашид ч авлигын эсрэг, шударга байдлыг бэхжүүлэхэд удирдлагын хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх шаардлага байсаар байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна. Тухайлбал, бусад дэд үзүүлэлтээс хол зөрүүтэй байгаа нь үүнийг баталж байна.

Хүснэгт 18. Дүүргүүдийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр 2025

№	Байгууллагын нэр	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	98.38	98.64	94.43	100.00	80.45	94.38
2	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	99.29	96.88	90.88	100.00	76.19	92.65
3	Багануур дүүргийн ЗДТГ	98.95	91.29	89.27	100.00	70.40	89.98
4	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	98.68	87.61	85.91	100.00	76.29	89.70
5	Налайх дүүргийн ЗДТГ	97.56	95.63	87.36	100.00	66.74	89.46
6	Багахангай дүүргийн ЗДТГ	99.50	93.10	83.33	100.00	69.71	89.13
7	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	97.67	97.77	81.70	95.00	69.97	88.42
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	99.23	94.72	66.43	100.00	71.62	86.40
9	Баянгол дүүргийн ЗДТГ	90.95	80.41	85.01	96.67	67.69	84.15
Дундаж үнэлгээ		97.80	92.89	84.93	99.07	72.12	89.36

2.6 ДШБҮ-ний гүйцэтгэл бага байгууллагууд

Энэ хэсэгт 2025 онд хамгийн бага ДШБҮ авсан байгууллагууд болон тус онд өмнөх оноос хамгийн их үнэлгээний бууралттай байгууллагуудын үнэлгээний үзүүлэлтүүдийг тус бүрчлэн задлан шинжлэв.

2.6.1 Хамгийн бага үнэлгээ бүхий байгууллагууд

Өмнөх 2.2 дугаар хэсэгт дотоод шударга байдлын үнэлгээгээр 2025 онд сүүлийн 5 эрэмбэд жагссан байгууллагуудыг харуулсан. Эдгээр байгууллагуудын 26 нэгж асуултын онооны дэлгэрэнгүйг хавсралт-5-д оруулав.

Хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудын энэ жилийн онцлогийг дурдвал, нэг Яам, дөрвөн агентлаг үнэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн жил хоёр аймгийн ЗДТГ сүүлийн байруудад жагсаж байсан бол энэ жил ЗДТГ-ууд сүүлийн байруудад ороогүй, харин дийлэнх нь агентлагууд орсон байна. Мөн түүнчлэн сүүлийн 23 байгууллагыг авч үзэхэд 61 хувь нь буюу 14 нь давхцаж байлаа. Эндээс дүгнэж үзэхэд жил бүрийн ШБҮ-ний зөрүү харьцангуй бага байдгийг илэрхийлэх бөгөөд мэдээлэл цуглуулах судалгаа чанартай явагддаг болхийг илэрхийлж байна. 2025 оны ДШБҮ-ээр сүүлийн 5 байр орсон байгууллагуудын дундаж үнэлгээ 2024 онтой харьцуулахад 3.9 оноогоор нэмэгдсэн байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

1. Мал эмнэлгийн ерөнхий газар

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны ДШБҮ-г өмнөх онтой нь харьцуулахад 20.47 оноогоор буурч 23 байр ухарсан нь өмнө дүгнэж байсан сүүлийн 23 байгууллага дотор хамгийн ихээр буурсан үзүүлэлт боллоо. ДШБҮ-ний эрэмбийн хамгийн сүүлд орсон Мал эмнэлгийн ерөнхий газрын үнэлгээний 7 дэд үзүүлэлтүүдийн үр дүн ба өөрчлөлтийг дараах хүснэгтэд харуулав. Тус байгууллагын хувьд 2025 онд үнэлгээний хамгийн өндөр бууралттай (-20.47↓) байгаа нь, мөн бүх дэд үзүүлэлтүүд өндөр дүнгээр буурч үнэлэгдсэн нь анхаарал татахаар байна.

Хүснэгт 19. Мал эмнэлгийн ерөнхий газрын ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	80.46	59.9	-20.47
I. Соёлын индекс	69.63	46.35	-23.28
Албан бус хэм хэмжээ	76.36	56.53	-19.83
Авлигын эсрэг тогтолцоо	62.9	36.18	-26.72
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	91.29	73.62	-17.7
Хүний нөөц	98.33	98.6	0.27
Төсвийн зарцуулалт	98.33	76.4	-21.93
Үүрэг даалгаврын шударга байдал	89.33	46.36	-42.97
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100	95	-5
Удирдлагын хүсэл эрмэлзэл	70.48	51.7	-18.78

Дээрх хүснэгтээс харахад тус байгууллагын хувьд авлигын эсрэг тогтолцоо, төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, удирдлагын хүсэл эрмэлзэл гэсэн 4 дэд үзүүлэлтүүд маш өндөр дүнгээр буурсан байна. Эдгээр 4 дэд үзүүлэлтэд харгалзах нэгж асуултуудын үнэлгээг харахад тус байгууллагын албан хаагчид нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг (22.5 оноо), удирдах албан хаагчид үүрэг хариуцлагаас зайлс хийдэг (26.38 оноо), хууль бус үүрэг даалгавар өгдөг (35.94 оноо), гэсэн хариултыг тус тус өгсөн байна⁶.

⁶ Нэгж асуулт бүр дээр авах дээд оноо 100

Цаашлаад тус байгууллагын 20 албан хаагчдаас 3 нь байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал байна гэж үзсэн бөгөөд тус зөрчлийн давтамжийг (A15.1 дүгээр асуулт) 52.41 оноогоор үнэлсэн нь давтамж өндөр байгааг илтгэж байна.

Тус байгууллагаас судалгаанд хамрагдсан 20 хүний 7 нь удирдлагаас хууль бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл ба маш түгээмэл гэж хариулсан. Цаашлаад албан үүргээ гүйцэтгэж байхад хууль бус үүрэг даалгавар өгөх явдал 7 албан хаагчдад тохиолдсон гэж хариулсан ба түүний давтамж нь олон байсан зэрэг шалтгаанаар үүрэг даалгаврын шударга байдал дэд үзүүлэлт 2.0 оноогоор үнэлэгдэхэд хүрсэн байна.

Дээд ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлд албан хаагчид нь харгалзан 50.33 ба 48.33 оноог тус тус өгсөн бөгөөд судалгаа өгсөн 20 албан хаагчдаас 4 нь л авлигатай тэмцэх үйл ажиллагаа сайжирсан хэмээн хариулж, үлдсэн нь “өөрчлөгдөөгүй”, “мэдэхгүй”, “дордсон”, “ихээхэн дордсон” гэж хариулт өгсөн. Авлигын нөлөөллийг 54.7 оноогоор буюу дунд зэрэг гэж үнэлсэн зэрэг нь удирдлагын хүсэл эрмэлзлийн оноог бууруулж байна.

Мал эмнэлгийн ерөнхий газарт ДШБҮ-ний үр дүн доогуур үзүүлэлттэй гарч байгаа шалтгааныг цаашид тодруулах шаардлагатай. Тухайлбал, тус байгууллагын чиг үүрэгт мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийг мөрдүүлэх замаар тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих зэрэг ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй үйл ажиллагаанууд байгаа эсэх, малын өвчний вакцин, эм тариа, тоног төхөөрөмжийн худалдан авалт, албан хаагчдын сургалт зэрэг үйл ажиллагаануудын зохион байгуулалтуудыг анхаарч, шинжлэх зэргээр хяналт тавьж болох юм.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Тус газар нь ДШБҮ-ний оноогоор эрэмбийн 71-р байранд, үнэлгээний бууралтаар мөн сүүлээсээ 7 дугаарт жагсаж байгаагаар өмнөх Мал эмнэлгийн ерөнхий газартай ойролцоо үр дүнг үзүүлж байна. Дараах хүснэгтээс харахад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 15 албан хаагчид асуулгын бүх дэд үзүүлэлтүүдийг өмнөх оноос багаар үнэлсэн байна.

Хүснэгт 20. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	75.4	67.7	(7.64)
I. Соёлын индекс	65.9	63.7	(2.19)
Албан бус хэм хэмжээ	76.8	75.5	(1.39)
Авлигын эсрэг тогтолцоо	55	52	(2.98)
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	84.9	71.8	(13.10)
Хүний нөөц	97.7	97.9	0.22
Төсвийн зарцуулалт	89.4	33.8	(55.66)
Үүрэг даалгаврын шударга байдал	76.5	73.5	(3.00)
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	96.7	96.7	-
Удирдлагын хүсэл эрмэлзэл	64	56.9	(7.06)

Төсвийн зарцуулалтыг зориулалтыг бусаар зарцуулдаг бөгөөд давтамж нь олон, хэмжээ нь их байгааг судалгааны үр дүн харуулсан байна. Тухайлбал, төсвийг зориулалтын бусаар зарцуулдаг давтамж хэр их байгааг үнэлсэн үнэлгээ өмнөх жилээс 94.65 оноогоор буурч үнэлэгдсэн бол төсвийн зориулалтын бус зарцуулалтын хэмжээг их байдаг (96.57) гэж үнэлсэн байна. Байгууллагын дотоод авлигын эсрэг тогтолцоо өмнөх жилээс буурч хангалтгүй үнэлгээтэй байна. Байгууллагын удирдлага өөрийн үүрэг хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх (A17 дугаар асуулт) явдал дундаж буюу түгээмэл гэж үзэн 61.54 оноогоор үнэлсэн байна.

Өмнөх оны ДШБҮ-ний эрэмбийн 63 дахь байрнаас энэ онд 71 дүгээр байр болж 8 байраар ухарч эрэмбэлэгдсэн нь тус газрын дотоод шударга байдлын үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгааныг цаашид тодруулах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хувьд бусад төрийн байгууллагуудаас ялгаатай нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, иргэдэд бие даан хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг (тусгайлан чиглэсэн бус) хэрэгжүүлдэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжих боломж, хүрэлцээ хангамж хангалттай биш байдаг зэрэг нь үнэлгээнд нөлөөлдөг байж болох юм. Ийм тус газрын удирдлагууд авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой төлөвлөвөл зохино.

3. Цаг уур, орчны шинжилгээний газар

Тус агентлаг нь 2024 оны судалгаагаар 53.35 оноо авч хамгийн сүүлийн байрт эрэмбэлэгдэж байсан бол 2025 онд ДШБҮ-гээ 16.89 оноогоор нэмэгдүүлж, 70.2 оноо авснаар 70 дугаар байранд эрэмбэлэгдэж өмнөх жилээс 2 байр урагшилсан байна. Энэхүү ДШБҮ-ий өсөлт нь нийт байгууллагаас эхний 3-т орох өндөр өсөлт юм.

Хүснэгт 21. Цаг уур орчны шинжилгээний газрын ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	53.3	70.2	16.89
I. Соёлын индекс	46	57.12	11.16
Албан бус хэм хэмжээ	66.5	66.21	(0.32)
Авлигын эсрэг тогтолцоо	25.4	48.04	22.66
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	60.7	83.28	22.61
Хүний нөөц	73.3	96.47	23.17
Төсвийн зарцуулалт	60.1	77.9	17.80
Үүрэг даалгаврын шударга байдал	52	82.43	30.47
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	85	100	15.00
Удирдлагын хүсэл эрмэлзэл	33	59.62	26.64

Цаг уур орчны шинжилгээний газрын ДШБҮ-ний хоёр индекс өсөлттэй гарсан бөгөөд 7 дэд үзүүлэлтийн Албан бус хэм хэмжээ өмнөх оноос буурсан бол бусад нь энэ жил 15 онооноос дээш үнэлгээгээр нэмэгдсэн байна. Харин төсвийн зориулалтын бус зарцуулалтын хэмжээ (A15-2) 58.8 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 40.6 оноогоор буурсан нь албан бус хэм хэмжээ буурах үндсэн шалтгаан болжээ.

Харин албан бус хэм хэмжээ буурахад хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйл бол байгууллагын албаны нууцтай холбоотой асуудал болох албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсвэл бусдад дамжуулах явдал хэр байдаг вэ гэсэн (A5) асуулгад судалгаанд оролцсон 20 төрийн албан хаагчаас 11 нь бага зэрэг, дунд зэрэг, түгээмэл гэж хариулсан нь мэдээллийн ил тод байдал, байгууллын мэдээллийг өөр давуу тал болгох ашиглах зэрэг зөрчил ихтэй болох нь харагдаж байна.

Тус агентлагийн үнэлгээ ийнхүү доогуур гарсан шалгаан нь ШБҮ-ний дийлэнх асуудалд дундаас доош үнэлгээ авсан нь нийт үр дүнд нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, хэт өндөр эсвэл хэт бага үнэлэгдсэн асуудал байхгүй, асуулга бүрийн үнэлгээний зөрүү бага буюу 50-70 онооны хооронд үнэлэгдсэн нь бусад байгууллагатай харьцуулахад доогуур үнэлгээ юм. Иймд цаг уур, орчны шинжилгээний газар авлигатай тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн үзүүлэлтэд зориулж бус цогцоор хийх нь үр дүнтэй байна. Тодруулбал, соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлыг илтгэдэг дэд үзүүлэлтүүдэд жигд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

4. Эрүүл мэндийн яам

ДШБҮ-ээр яамдууд дотроос хамгийн багаар үнэлэгдсэн нь Эрүүл мэндийн яам 2024 онд 77.88 оноотой 58 дугаар байрт эрэмбэлэгдэж байсан бол энэ жилийн судалгаагаар өмнөх оноос 6.55 оноо буурч, 71.33 оноотой үнэлэгдэн 69 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна.

Эрүүл мэндийн яамны хоёр индекс, 7 дэд үзүүлэлтийн хүний нөөцийн асуудлаас бусад нь бүгд өмнөх оноос буурсан нь доорх хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 22. Эрүүл мэндийн яамны ДШБҮ, түүний дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	77.9	71.33	(6.57)
I. Соёлын индекс	68.5	61.42	(7.08)
Албан бус хэм хэмжээ	76.3	71.42	(4.88)
Авлигын эсрэг тогтолцоо	60.6	51.42	(9.18)
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	87.3	81.23	(6.07)
Хүний нөөц	96	96.08	0.08
Төсвийн зарцуулалт	95.8	84.1	(11.7)
Үүрэг даалгаврын шударга байдал	79	71.05	(7.95)
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	99	98	(1.00)
Удирдлагын хүсэл эрмэлзэл	66.8	56.95	(9.85)

Байгууллагын авлига, ашиг сонирхлын эсрэг тогтсон албан бус хэм хэмжээг үнэлэх асуултуудаас харахад албан үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдлыг хангадаг эсэх, ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг эсэх, танил талын нөлөөнд автах байдал ба бусдад дарамт, шахалт үзүүлдэг эсэх асуултууд (A1-A4) 60-70 оноогоор үнэлэгдсэн бөгөөд өмнөх оноос буурсан үнэлгээтэй гарчээ. Судалгаанд оролцогчид байгууллагын удирдах алба хаагчид өөрийн үүрэг хариуцлагаас зайлс хийх тохиолдол түгээмэл (52.78 оноо) гэж үнэлсэн ба авлига, ашиг сонирхлын зөрчилд хариуцлага тооцох байдалд (A8) 50.68 оноо өгсөн байна.

Авлигатай тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзлийн дундаж оноо 59.09 оноогоор үнэлэгдэж, байгууллагын авлигын нөлөө 65.52⁷ оноогоор тус тус үнэлэгдсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үнэлгээний үр дүнтэй адил талууд Эрүүл мэндийн яаманд мөн харагдаж байна. Тэдгээр нь байгууллагын дотоод авлигын эсрэг тогтсон хэм хэмжээ ба эсрэг механизм сул, гадаад орчин дахь авлигатай тэмцэх үзүүлэлтүүд буурсан зэрэг байна. Үүнд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газруудын онцлог, орчин нөлөөтэй байж болох юм. Үүнийг дараагийн дүгнэлтэд орж буй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас мөн харж болно.

5. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын ДШБҮ нь 2025 онд 71.42 оноогоор үнэлэгдсэн нь өмнөх оноос 9.87 оноогоор буурч, 22 байраар эрэмбэ нь хойшлогдож хамгийн бага үнэлгээтэй 5 байгууллага болсон байна. Үнэлгээнд ашигласан 7 дэд үзүүлэлтээс байгууллагын дотоод авлигын эсрэг тогтолцоо хамгийн баг оноогоор үнэлэгдсэн хэвээр бөгөөд авлига, ашиг сонирхлын мэдээлэгчийг хамгаалсан байдалд 53.57 оноо, авлигыг хянах дотоод механизмын бүрдэлд 47.5 оноо, төсвийн зориулалтын бус зарцуулалтын давтамж 32.99 оноо, албан тушаалтан өгсөн үүрэг даалгавраас зайлс хийх, эс үйлдэх хандлага 46.30 оноог тус тус өгсөн байна. Авлигын эсрэг соёлын албан бус хэм хэмжээг илэрхийлэх 6 нэгж асуултуудын 4 нь 75-аас доош оноогоор үнэлэгдсэн байна.

⁷ 100 оноо нь авлигын нөлөө огт байхгүйг илэрхийлнэ.

Хүснэгт 23. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ДШБҮ, дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	81.3	71.42	(9.87)
I. Соёлын индекс	76.9	65.19	(11.74)
Албан бус хэм хэмжээ	86	76.1	(9.90)
Авлигын эсрэг тогтолцоо	67.9	54.28	(13.58)
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	85.6	77.65	(7.99)
Хүний нөөц	98.3	96.84	(1.49)
Төсвийн зарцуулалт	77.7	57.76	(19.92)
Үүрэг даалгаврын шударга байдал	87.8	74.55	(13.29)
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100	100	-
Удирдлагын хүсэл эрмэлзэл	64.4	59.08	(5.28)

Тухайн байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхэд үнэ бүхий эд зүйлс өгөх явдал хэр түгээмэл вэ гэсэн асуултад 84.21 оноо, сүүлийн 12 сарын хугацаанд өөрийн албан тушаалтанд дээрх асуудлаар үнэ бүхий зүйлс өгч байгаагүй буюу 100 оноогоор үнэлэгдсэн. Мөн түүнчлэн өмнөх 4 байгууллагаас ялгаатай нь төсвийг зориулалтын бусаар зарцуулдаггүй, харин албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх явдаг гардаг буюу 67.86 оноогоор үнэлэгдсэн байна.

2.6.2 ДШБҮ хамгийн ихээр буурсан байгууллагууд

2025 оны төр захиргааны байгууллагуудын ДШБҮ-ний ерөнхий дундаж бага зэрэг буюу 0.83 оноогоо нэмэгдсэн. Эдгээр 72 байгууллагаас 39 байгууллагын ДШБҮ өсөлттэй гарсан бол 33 байгууллагын үнэлгээ буурч үнэлэгджээ. Үүнээс хамгийн их өөрчлөлт орсон байгууллагуудыг дараах хүснэгтээр харууллаа. ДШБҮ-ний хамгийн их өөрчлөлтийн үр дүнгээс харахад бууралт -20 оноо байсан бол өсөлт нь +20 оноо байлаа. Энэ нь онооны хэлбэлзэл хэвийн тархалттай болохыг харуулж байна. Нөгөө талаар буурч үнэлэгдсэн байдал ДШБҮ-г өсгөхөд их хэмжээний хүчин чармайлт гаргах шаардлагатай гэж дүгнэж байна. Өнгөрсөн онд өсөлт бууралтын зөрүү 20 оноогоор хэмжигдэж байсан бол өнөө жилийн 40 гаруй онооны өөрчлөлттэй байгаа нь анхаарал татаж байна⁸.

Хүснэгт 24. ДШБҮ хамгийн их өөрчлөлттэй байгууллагууд

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор		
		ДШБҮ-ний	Соёлын индексийн	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн
Хамгийн өндөр өсөлттэй				
1	Биеийн тамир, спортын улсын хороо	23.08	19.68	26.49
2	Ховд аймгийн ЗДТГ	17.31	26.29	8.33
3	Цаг уур, орчны шинжилгээний газар	16.89	11.16	22.62
4	Батлан хамгаалах яам	13.58	14.53	12.64
5	Үндэсний геологийн алба	12.45	13.89	11.00
Хамгийн өндөр бууралттай				

⁸ Энэхүү онооны зөрүү нь өмнөх оноос өөрчлөгдсөн дүнг харуулж байгаа тул тухайн жилийн байгууллагуудын үнэлгээний хоорондыг зөрүүг харуулахгүй болно.

1	Мал эмнэлгийн ерөнхий газар	(20.47)	(23.28)	(17.67)
2	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	(12.75)	(17.64)	(7.86)
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	(9.87)	(11.74)	(8.00)
4	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	(9.84)	(11.51)	(8.17)
5	Жижиг, дунд үйлдвэрийн газар	(8.56)	(4.89)	(12.22)

Энэ дэд хэсэгт, 2025 оны судалгаагаар хамгийн бага гүйцэтгэлтэй гарсан байгууллагуудыг онцолж байгаа учир үнэлгээ хамгийн ихээр буурсан байгууллагуудыг цаашид нарийвчлан авч үзье. 2.6.1 хэсэгт Мал эмнэлгийн ерөнхий газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газруудын үнэлгээний бууралтыг өмнө дүгнэж бичсэн билээ.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын хувьд гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдлаас бусад 6 дэд үзүүлэлтүүд бүгд өмнөх оноос багаар үнэлэгдсэн ба нэгж үзүүлэлтүүдийн үнэлгээ 2025 онд хэрхэн тодорхойлогдсоныг хавсралт 6 – аас харах боломжтой. Албан бус хэм хэмжээний үзүүлэлтэд хамаарах 6 асуултын 5 нь 70-аас доош, үлдсэн нэг нь 90-ээс доош оноо авсан нь албан бус хэм хэмжээ буурахад нөлөөлжээ. Авлигын эсрэг тогтолцооны гурван асуулт бүгд 61 ба түүнээс доош үнэлгээтэй байна. Авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг талаар (А8) 68 оноо, авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдсэн эсэх талаар (А9) 46.88 оноо авсан нь авлигын эсрэг тогтолцоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Байгууллагын удирдлага өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл вэ гэсэн асуултад 55.8 оноо өгсөн нь үүрэг даалгаврын шударга байдлын үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлсэн бол, удирдлагаас хууль бус үүрэг даалгавар өгөх тохиолдолд 71.88 оноо өгсөн нь тус индексийг нэмэгдүүлэх үзүүлэлт болжээ.

Хүснэгт 25. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын ДШБҮ, дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	85.6	72.83	(12.75)
I. Соёлын индекс	79.2	61.53	(17.64)
Албан бус хэм хэмжээ	80.1	69.5	(10.55)
Авлигын эсрэг тогтолцоо	78.3	53.56	(24.74)
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	92	84.13	(7.87)
Хүний нөөц	98.8	97.5	(1.25)
Төсвийн зарцуулалт	94.6	86.17	(8.46)
Үүрэг даалгаврын шударга байдал	91.5	79.7	(11.83)
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100	100	-0.00
Удирдлагын хүсэл эрмэлзэл	75.1	57.29	(17.79)

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ДШБҮ-ний бууралтад хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлс соёлын индекс (11.51↓) доторх авлигын эсрэг тогтолцоо (13.56↓) буурсан нь бусад индекс болон дэд үзүүлэлтүүдээс хамгийн ихээр буурсан дүн болж байна. Тухайн дэд үзүүлэлт дотор асуултуудын үнэлгээг авч үзэхэд 80-аас дээш үнэлгээ авсан хоёр асуулга байгаа бол үлдсэн 4 асуулга 80 ба түүнээс бага оноогоор үнэлэгдсэн байна. Хавсралт 6-аас харахад тухайн байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал дунджаас бага хэмжээнд байдаг (А14=79.81 оноо), сүүлийн жилд тийм тохиолдол бага зэрэг буюу судалгаанд хамрагдсан 50 төрийн албан хаагчаас таван албан хаагч үүссэн (А15=90.00 оноо) гэж хариулсан ба тохиолдлын давтамж маш цөөн (А15.1=83.71 оноо), мөнгөн дүн бас маш бага байсан (А15.2=97 оноо) гэж хариулсан нь тус яамны ДШБҮ-д эерэг нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 26. Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын ДШБҮ, дэд үзүүлэлтүүд

Индекс, дэд үзүүлэлтүүд	2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ДШБҮ	91.7	83.17	(8.56)
I. Соёлын индекс	86.4	81.54	(4.89)
Албан бус хэм хэмжээ	93.2	84.83	(8.35)
Авлигын эсрэг тогтолцоо	79.7	78.24	(1.44)
II. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	97	84.8	(12.22)
Хүний нөөц	99.3	95.89	(3.36)
Төсвийн зарцуулалт	100	71.53	(28.47)
Үүрэг даалгаврын шударга байдал	98.1	87.17	(10.93)
Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100	95	(5.00)
Удирдлагын хүсэл эрмэлзэл	87.7	74.38	(13.37)

Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын ДШБҮ өнгөрсөн жил тэргүүлж байсан бол 2025 онд 8.58 оноогоор буурч, 38 дугаар байр хүртэл огцом буурсан байна. Тус газрын хоёр индекс 7 дэд үзүүлэлт бүгд буурсан бөгөөд төсвийн зарцуулалт, удирдлагын хүсэл эрмэлзэл, үүрэг даалгаврын шударга байдал зэрэг дэд үзүүлэлтүүд илүү хэмжээгээр буурсан бол хамгийн бага хэмжээгээр буурсан үзүүлэлтэд авлигын эсрэг тогтолцоо, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал зэрэг дэд үзүүлэлтүүд багтаж байна. Дэд үзүүлэлтүүдэд харьяалагдах асуулгуудыг шинжилж үзэхэд дийлэнх асуулга дундаас дээш буюу 70 -аас дээш оноогоор үнэлэгдсэн боловч өмнөх онтой харьцуулж үзэхэд үнэлгээ нь сайжирсан буюу нэмэгдэж үнэлэгдсэн асуулга байхгүй байна. Эдгээр бууралтаас соёлын индекс дэх албан бус хэм хэмжээг илэрхийлэх танил талын нөлөөнд автдаг талаарх асуулт 11.48 оноогоор, мэдээллийн ил тод байдлыг тодорхойлох асуудал 15.63 оноогоор, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг тооцдог асуудал болох удирдах албан тушаалтанд мөнгө, үнэ бүхий зүйл өгч байсан эсэх 15.38 оноогоор тус тус буурсан нь Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын ДШБҮ-ний оноо буурахад голлох нөлөө үзүүлсэн байна.

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ


Энэ бүлэгт Монгол Улс дах авлигын шалтгаан, нөхцөл, авлига хамгийн их тархсан институтын талаар, ирэх 2 жил авлигын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл болон АТГ-ын үйл ажиллагааг төрийн байгууллагуудын албан хаагчид хэрхэн үнэлснийг орууллаа.

3.1. Монгол Улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, шалтгаан

Монгол улсын авлигын өнөөгийн нөхцөл байдлыг төрийн байгууллагуудын албан хаагчид хэрхэн үнэлж байгааг тодруулахаар Монгол улсад авлига хэр түгээмэл байна вэ гэсэн асуултыг тавихад дараах үр дүн гарлаа. Үүнд судалгаанд оролцогчдын 60.3 хувь нь ихээхэн түгээмэл ба түгээмэл гэж хариулсан байна. Тус асуултын үр дүнг өмнөх онуудтай харьцуулан дараах графикт харуулав.

Авлигын түгээмэл байдлын талаар хариултыг өмнөх онтой харьцуулахад ихээхэн түгээмэл болон түгээмэл гэсэн хариултууд харгалзан 2% ба 0.5%-аар нэмэгдсэн мэт харагдаж байгаа ч энэхүү өсөлт нь мэдэхгүй гэж хариулсан болон хариулаагүй хүмүүсийн өсөлтөөр нөхөгдөж байна⁹. Харин дунд зэрэг болон бага гэсэн хариултууд буурсан байгаа нь энэ оны судалгаагаар албан хаагчдын дундах авлигын түгээмэл байдлын төсөөлөл бага зэрэг буурсан гэж үзэж болохоор байна.

График 14. Монгол Улсын авлигын өнөөгийн байдал, хувиар



Монгол Улсад авлига түгээмэл гэсэн хариулт өөрчлөгдөхгүй байгаа шалтгааныг судалгаанд оролцогчдод нээлттэй байдлаар тавьсан “Монгол улс дахь авлигын үндсэн шалтгаан, нөхцөлийг нэрлэнэ үү” гэсэн асуултын хариултаас эрэлхийлье. Албан хаагчдын хамгийн ихээр дурдсан эхний 3 хариулт өмнөх оны үр дүнтэй байр нь солигдсон боловч ижил байна. Тухайлбал, 2024 онд авлигын шалтгааныг тодруулах нийт хариултын 28.6 хувийг цалин хөлсний хэмжээ бага, амьжиргааны түвшний доогуур байдал гэсэн хариу бүрдүүлж байсан бол энэ онд 29 хувь болон нэг нэгж хувиар нэмэгдсэн байна. Хувь хүний хандлага, ухамсар гэсэн хариулт өмнөх онд нийт хариултын 11.7% байсан бол энэ онд 8% байна. Хуулийн хэрэгжилт сул, хуулиа мөрддөггүй байдал нь нэг шалтгаан болж байна

⁹ Хэрэв хувийн жинг тооцохдоо асуултад хариулаагүй эсвэл мэдэхгүй гэсэн сонголтыг хасвал ихээхэн түгээмэл гэсэн хариулт өмнөх оноос 4.5 нэгж хувиар, түгээмэл гэсэн асуулт 1.4 нэгж хувиар тус тус бууралттай байхаар байна.

гэсэн хариулт өмнөх онд 7.3% байсан бол энэ онд хуулиа мөрддөггүй, хариуцлага тооцдоггүй гэж 5% нь үзсэн байна.

Хүснэгт 27. Монгол Улс дахь авлигын үндсэн, шалтгаан нөхцөлийн талаарх төсөөлөл

№	Хариултын утга	Нийт хариултад эзлэх хувь
1	Цалин хөлс бага	17%
2	Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлт	12%
3	Хувь хүний хандлага, шунал, ёс зүй	8%
4	Төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл их	7%
5	Хүнд суртал их	7%
6	Хяналт сул, хариуцлага тооцдоггүй байдал	6%
7	Мэдэхгүй/хариулаагүй	5%
8	Шударга бус (хууль, дүрэм, журам ижил тэгш үйлчилдэггүй)	5%
9	Мэдээллийн ил тод бус байдал, сургалт сурталчилгаа хангалтгүй	5%
10	Улс төр, бизнесийн бүлэглэл холилдсон	4%
11	Эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл бий болсон	3%
12	Танил тал, хамаатан садны холбоо, гар цайлгах уламжлалт буруу хандлага	3%
13	Тогтолцооны гажуудал	3%
14	Эрх зүйн орчин хангалтгүй	3%
15	Ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс тухайн салбарт төрийн албанд ажилладаг	3%
16	Төрийн үйлчилгээний ачаалал их	2%
17	Ажлаа хурдан бүтээх хүсэл	2%
18	Боловсрол муу (хуулийн мэдлэг АТГ-тай тэмцэх талаар мэдлэггүй болон бусад)	1%
19	Төрийн алба хаагчийн хариуцлагагүй байдал	1%
20	Гар цайлгах, уламжлалт сэтгэлгээ	1%
21	Төрийн байгууллага хангалттай цахимжаагүй	0%
22	АТГ мэдээлэл өгөх боломжуудыг нэмэгдүүлж, нууцлах	0%

Дээрх хүснэгтээс харахад авлигын үндсэн шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэгч хүчин зүйлсэд төдийлөн өөрчлөлт гарахгүй байна гэж судалгаанд оролцсон төрийн албан хаагчид үзжээ. Эдгээр нь цалин хөлс бага, амьжиргааны түвшин бага, хувь хүний шударга байдал, ёс зүй, хуулийн хэрэгжилт, хариуцлагын тогтолцооны хөгжил, ил тод бус байдал гэсэн хүчин зүйлс байна. Энэ жилийн авлигын шалтгаан нөхцөлд шинээр орж ирсэн санал нь хэдий бага боловч АТГ-т гаргаж буй гомдлыг олон хэлбэрээр авдаг байх бөгөөд нууцыг чанд хадгалдаг байх тухай санал хэдийгээр эзэлж буй хувийн жин бага боловч хэд хэдэн төрийн албан хаагч дурдсан байна.

3.2. Авлига хамгийн их тархсан институт

Судалгаанд оролцсон албан хаагчдаас Монгол Улсад авлига хамгийн их тархсан институт аль нь болохыг тодруулах асуултын хариуг нийт судалгаанд оролцогчдын хэдэн хувь нь тухайн байгууллагад авлига хамгийн их тархсан гэж үзэж буйгаар дараах хүснэгтэд харуулав. Өмнөх онуудтай адилаар Шүүх, Эрүүл мэндийн байгууллага, Газрын алба, Улс төрийн нам болон Гаалийн байгууллагууд хамгийн өндөр хувьтай хэвээр байна.

Хүснэгт 28. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор

Байгууллага	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ
Газрын алба	37.50%	44.62%
Гаалийн байгууллага	33.70%	44.62%
Татвар	18.30%	43.95%
Шүүх	42.90%	43.42%
Эрүүл мэндийн байгууллага	40.00%	26.80%
Улс төрийн нам	34.90%	26.80%
Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	27.80%	26.80%
Хэвлэл мэдээллийн байгууллага	19.20%	26.80%
Цагдаагийн байгууллага	19.10%	24.92%
Прокурорын байгууллага	19.30%	23.76%
Мэргэжлийн хяналтын байгууллага	17.40%	18.53%
Төрийн бус байгууллага	4.90%	5.79%
Хувийн хэвшил	4.40%	5.56%
Боловсролын байгууллага	24.10%	5.56%
Нутгийн захиргааны байгууллага	19.50%	2.86%
Бусад	3.80%	2.86%

Албан хаагчдын дээрх үнэлгээнээс харахад иргэд үйлчлүүлэхэд хамгийн их чирэгдэл, бэрхшээлтэй, цаг хугацаа шаардсан, шат дамжлага ихтэй байгууллагуудад авлига хамгийн их тархдаг гэж үзжээ. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллага, гаалийн байгууллага, газрын албаны хувьд ачаалал их, үйлчилгээний хүртээмж багаас шалтгаалж иргэд богино хугацаанд үйлчилгээ авах, дарааллын урдуур үйлчлүүлэх зэрэг зорилгоор авлига өгөх хандлага их гэж үзэх боломжтой байна.

Манай улсын хувьд судалгаанд оролцсон төрийн алба хаагчид газрын албыг авлига хамгийн ихээр тархсан газар гэж дүгнэсэн бөгөөд өнгөрсөн оноос 7.12 хувиар нэмэгджээ.

Газрын алба дээр авлига, хүнд суртал их байдаг шалтгаан нь газар өндөр үнэ цэнтэй нөөц төдийгүй Монгол Улсын иргэн газар өмчлөх эрхтэй боловч дийлэнх иргэд газар өмчилж аваагүй байдаг тул газар өмчлөх сонирхолтой иргэдийн үйлчилгээ авах дараалал ихтэйгээс ачаалал үүсэж, төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байдагтай холбоотой. Нөгөө талаар үл хөдлөх хөрөнгийн үнэ цэн өгөөж их байдаг тул иргэдийн хооронд газрын арилжаа, наймаа, шилжүүлэг их хийгддэг нь тухайн байгууллагууд ажлын ачааллыг нэмэгдүүлдэг. Гэтэл газрын албаны мэдээллийн ил тод бус байдал, тодорхойгүй дүрэм журам, удаан хойрго ажиллагаа, хүнд суртал, газрын албаны алба хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, техник технологи, цахим харилцааны хоцрогдол гэх мэт олон хүчин зүйлс тус газрыг авлига хамгийн их тархсан газар болгон хувиргаж байна.

Газрын алба өнгөрсөн жил 37.5 хувиар хамгийн их авлига тархсан байгууллага гэж 3-т эрэмбэлэгдэж байсан бол 2025 оны судалгаагаар төрийн байгууллагуудаас хамгийн өндөр хувийг эзэлж тэргүүлж байна. Иймд цаашид газрын албаны үйл ажиллагааг цахимжуулах, хиймэл оюунд суурилсан мэдээллийн технологи ашиглах зэрэг дэвшилтэт технологи ашиглах шаардлагатай байна.


Шүүх байгууллагын хувьд иргэдийн шүүхэд итгэх итгэл доогуур байдагтай холбоотойгоор авлига их тархсан байгууллагаар үнэлэгдсэн гэж үзэж байна. Тухайлбал, 2023 онд зохион байгуулсан “Хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх ба шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх нь” олон улсын хурлын үеэр танилцуулсан судалгаанд Монгол Улсад шүүх ажиллагаанд оролцсон иргэдийн шүүхэд итгэх итгэл 64.5 хувьтай, оролцож байгаагүй иргэдийн хувьд 53.7 хувьтай байгаа нь доогуур үзүүлэлт юм. Улс төрийн намуудын хувьд алба хаагчдын зүгээс намын санхүүжилтийн механизм, албан тушаалын томилгоо, хувийн

ашиг сонирхлыг дээгүүр үзэх зэрэг талуудад байнга шүүмжлэлтэй ханддаг нь дээрх хариултыг өгөхөд нөлөөлсөн байж болно.

3.3. Ирэх 2 жилд Монгол Улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл

Төрийн байгууллагуудын албан хаагчид Монгол Улсын авлигын түвшин ирэх хоёр жилд хэрхэн өөрчлөгдөх талаар ямар төсөөлөлтэй байгааг судалгааны асуулгаар асуухад дараах хариултуудыг өгсөн байна. Энэ оны хувьд нийт оролцогчдын 20.7 хувь нь авлигын түвшин тодорхой хэмжээнд буурна гэж үзсэн нь өнгөрсөн оноос 2.2 хувиар буурсан бол мэдэхгүй гэсэн хариултын хувь өндөр буюу 36 хувьтай байна. Харин авлига өснө гэсэн төсөөлөл 13.9 хувиар нэмэгдсэн нь өмнөх жилтэй харьцуулахад 0.9 нэгж хувиар нэмэгдсэн байна. Энэ нь авлига хамгийн их дэлгэрсэн газарт шүүх 2 дугаарт эрэмбэлэгдэж байгаа байдалтай логик холбоотой байна. Өөрөөр хэлбэл авлига ирэх жилүүдэд өсөх магадлалтай бөгөөд шударга ёсыг тогтоох үүрэгтэй шүүхэд авлига их тархсан гэж үзэж байгаатай холбоотой байж болох юм. Мөн түүнчлэн авлига өөрчлөгдөхгүй болон буурна гэсэн хариултууд буурч байгаа нь ирэх жилүүдэд авлига буурах талаар төрийн алба хаагчид итгэл найдваргүй байгааг харуулж байна. Энэ жилийн судалгааны үр дүнгээр өнгөрсөн жилийн хариултаас авлига буурна гэсэн хувь буурч, өснө гэсэн хариулт нэмэгдсэн нь Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгож, Шүгэл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 2024 онд иргэд, албан хаагчдын хувьд энэхүү ажиллагааны талаарх хүлээлт өндөр байсантай холбоотой байж болно. Харин 2025 онд судалгаанд оролцогчид 5 Ш ажиллагаа нь үр дүнтэй байсан нь эсэх эргэлзээтэйн дээр 5Ш ажиллагааны үр дүнг иргэдэд хангалттай мэдээлээгүй зэрэг нь энэ жилийн үнэлгээнд нөлөөлж, итгэл найдвар алдарсан байж болох юм.

График 15. Ирэх 2 жилд Монгол Улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл, хувиар




3.4 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн

Монгол Улсын авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, хариуцлага тооцох эрх, үүрэг бүхий байгууллага болох Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг үнэлэх нэг асуултыг судалгааны хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдаас авсан. Албан хаагчдын 16.7 хувь нь үр ашигтай ба ихээхэн үр ашигтай гэж хариулсан нь өмнөх онтой адил түвшинд байна. Харин төрийн албан хаагчдын 38 хувь дунд зэрэг гэж хариулсан

бөгөөд өмнөх онтой харьцуулахад 4 хувиар буурчээ. Судалгаанд оролцогчдын 22 хувь нь үр ашиггүй/огт үр ашиггүй гэж хариулсныг өмнөх онтой харьцуулахад 2 хувиар нэмэгджээ. Өмнөх жилүүдийн үнэлгээг харахад 2023 оноос бусад онуудад үнэлгээний хандлага 2025 оны үнэлгээтэй төстэй байна. 2023 онд албан хаагчдын дунд авлигын эсрэг үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаарх төсөөлөл эерэг байсныг өмнөх асуултын болон энэ асуултын үр дүн харуулж байна. Гэвч 2024–2025 онд энэхүү эерэг төсөөлөл эргээд буурсан, тодорхойгүй байдал нэмэгдсэн байдалтай байна.

График 16. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар



ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээг тодорхойлох зорилгоор албан хаагчдаас авсан асуулгын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна.

- 2018 оноос дараалан өсөлттэй байсан ДШБҮ энэ 2024 онд 81.5 болж өмнөх оноос 1.9 оноогоор буурсан бол энэ онд 82.41 болж өмнөх оноос 0.9 оноогоор буцаад өссөн байна. Өөрчлөлтийг байгууллагын төрлөөр нь задалж үзвэл¹⁰ яамдын ДШБҮ 0.76 оноогоор, агентлагуудын ДШБҮ 1.27 оноогоор, ЗДТГ-уудын ДШБҮ 0.54 оноогоор тус тус өссөн байлаа. Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ нь 2025 онд өсөлттэй гарснаас гадна нийт 72 байгууллагын 39 байгууллага өсөлттэй, 33 байгууллага буурч үнэлэгдсэн. Харин бүрэлдэхүүн хэсгүүдээр нь авч үзвэл соёлын индекс 1.7 оноогоор өссөн байхад, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 0.07 оноогоор үл ялиг буурч үнэлэгдсэн байв.
- 2025 онд Оюуны өмчийн газар, Боловсролын ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Сангийн яам ба Усны газар гэсэн 5 байгууллага ДШБҮ-ний эрэмбэд тэргүүлсэн бол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Цаг уур, орчны шинжилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар ДШБҮ-ээр сүүлийн 5 байрт эрэмбэлэгджээ.
- Хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн 5 байгууллагад дараах нийтлэг шинжүүдтэй байна. Үүнд:
 - Авлигын эсрэг хамгийн багаар буюу 54 онооноос багаар үнэлэгдсэн бол гадаад орчинтой авлигатай тэмцэх байдал 95-аас дээш оноогоор үнэлэгдсэн байна.
 - Төсвийн зориулалтын бус зарцуулалт болон удирдах албан хаагчид хууль бус үүрэг даалгавар өгдөг байдал нь ихээр нөлөөлсөн байна.
- Төрийн байгууллагууд, тэр дундаа ДШБҮ-ээр хамгийн сүүлийн байранд эрэмбэлэгдсэн байгууллагууд дараах хэд хэдэн зүйлд анхаарч, авлигын эсрэг төлөвлөгөөнд тусгаж ажиллах шаардлагатай байна. Үүнд:
 - Зөрчлийн талаар мэдээлэл өгсөн мэдээлэгчийн хамгаалах тогтолцоог бий болгох.
 - Зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлага хүлээлгэдэг байх систем бий болгох.
 - Авлигыг хянах дотоод механизм бүрэлдүүлэх талаар анхаарч ажиллах. Эдгээр асуудлууд нь шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэн, авлигыг бууруулахад юу хийх шаардлагатай талаар задгай асуултад хамгийн их дурдагдаж байсан үзүүлэлтүүд юм.
- 2025 оны ДШБҮ-ээг 2024 онтой харьцуулахад хамгийн өндөр өсөлттэй 5 байгууллагад Биеийн тамир спортын улсын хороо, Ховд аймгийн ЗДТГ, Цаг уур, орчны шинжилгээний газар, Батлан хамгаалах яам, Үндэсний геологийн алба 12 ба түүнээс дээш оноогоор нэмэгдэж үнэлэгджээ. Эдгээрээс 2024 онд 71 дүгээр байрт эрэмбэлэгдэж байсан Ховд аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 17.31 оноогоор нэмэгдэж, 17

¹⁰ Байгууллагаар нь гаргасан ДШБҮ-ний ерөнхий дунджид дүүргүүдийн ДШБҮ-г оруулалгүйгээр яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ гэсэн 72 байгууллагын шударга байдлын дунджаар хэмжиж орууллаа. Учир нь дүүргийн ДШБҮ-ээг сүүлийн 3 дахь жилдээ хийж байгаа тул 5 жилийн харьцуулалтаар дүгнэж байгаа тайланд зөрүү үүснэ гэж үзсэн болно.

байраар урагшилж эрэмбэлэгдсэн байна. Харин ДШБҮ нь хамгийн их буурсан үнэлгээтэй байгууллагаар Жижиг дунд үйлдвэрийн газар, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газрууд үнэлгээ нь буурсан 33 газрыг тэргүүлсэн байна. Эдгээр байгууллагууд 8-20 оноогоор буурчээ. Тухайлбал, 2024 оны ДШБҮ-ээр байгууллагуудыг тэргүүлж байсан Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын үнэлгээ 8.5 оноогоор буурч энэ онд 38 дугаар байранд жагсаж байна. Бага үнэлгээ авахад нөлөөлсөн нэгж үзүүлэлтүүдийн хувьд байгууллагууд харилцан адилгүй байв.

- ДШБҮ-ний нийт дүнд соёлын индексийн хоёр дэд үзүүлэлт эергээр, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн 5 дэд үзүүлэлтээс 2 дэд үзүүлэлт нь сөргөөр нөлөөлж байгаа боловч нөлөөллийн хүч нь бага буюу -1.7-оос 2.2-н хооронд зөрүү нь тодорхойлогдож байна.
